


# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СИСТЕМИЙН ДИНАМИК ЗАГВАР



*тайлан*

“СИСТЕМИЙН ДИНАМИК ЗАГВАРЧЛАЛ” ТББ

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН



Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам  
байгууллага



Олон улсын шилжилт хөдөлгөөний

## **БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СИСТЕМИЙН ДИНАМИК ЗАГВАР**

**БОЛОВСРУУЛСАН:**

Б.Ууганбаяр

Т.Баяртөгс

Ж.Жаргал

А.Мөнхболд

Д.Ариун-эрдэнэ

А.Элбэгжаргал

У.Баясгалан

М.Гэрэлт-од

## АГУУЛГА

УДИРТГАЛ.....	1
<b>СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ .....</b>	<b>2</b>
Баян-ӨЛГИЙ АЙМГИЙН Хүн ам.....	3
Баян-Өлгий аймгийн шилжих хөдөлгөөн.....	8
Хүн амын төрөлтийн хэсэг .....	16
Хүн амын нас баралтын хэсэг .....	24
Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлт .....	25
Нийгмийн халамж.....	30
Цэцэрлэгийн сектор .....	26
Бага боловсролын сектор.....	28
Бүрэн дунд боловсролын сектор .....	29
Эрүүл мэнд.....	31
Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн салбарын ерөнхий төлөв .....	33
Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн системийн динамик загвар.....	38
Мал аж ахуй .....	38
Газар тариалан .....	40
Баян-Өлгий аймгийн худалдаа үйлчилгээний салбарын ерөнхий төлөв байдал.....	43
Баян-Өлгий аймгийн худалдаа үйлчилгээний салбарын загвар .....	45
Баян-Өлгий аймаг аялал жуулчлалын салбарын одоогийн байдал.....	46
Баян-Өлгий аймаг аж үйлдвэрлэлийн салбарын одоогийн байдал.....	50
Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн загвар .....	54
Баян-Өлгий аймгийн барилгын салбарын ерөнхий төлөв байдал .....	55
Баян-Өлгий аймгийн барилгын салбарын хэтийн төлөв .....	56
Баян-өлгий аймгийн уул уурхайн салбарын хэтийн төлөв .....	57
Эдийн засгийн гол үзүүлэлтүүд.....	58
Дотоодын нийт бүтээгдэхүүн .....	58
Хөдөлмөр эрхлэлт.....	61
Симуляци.....	65
Симуляци 1. Аялал жуулчлалын маршруут .....	65
Симуляци 2: Нисэх онгоцны буудал.....	68
Симуляци 3: Арьс шир .....	69
Симуляци 4: Ноолуур .....	71
Симуляци 5: Ноос.....	72
Симуляци 6: Сарлагийн хөөвөр.....	72
ДҮГНЭЛТ .....	76
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	78

### **Зургын жагсаалт**

Зураг 1: Баян-Өлгий аймгийн хүн амын системийн динамик загвар.....	3
Зураг 2: Хүн амын төрөлтийн сектор .....	23
Зураг 3: Нас баралтын сектор.....	24
Зураг 4: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2010-2040.....	27
Зураг 5: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2010.....	28
Зураг 6: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2030.....	29
Зураг 7: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2020.....	30
Зураг 8: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2040.....	31
Зураг 9: Хүн амын эдийн засгийн идэвхийн бүдүүвч зураг /2020 он/.....	25
Зураг 10: Цэцэрлэгийн сектор.....	27
Зураг 11: Бага боловсролын сектор.....	28
Зураг 12: Бүрэн дунд боловсролын сектор .....	29
Зураг 13: Эрүүл мэндийн сектор .....	31
Зураг 14: Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн загвар .....	38
Зураг 15: Баян-Өлгий аймгийн газар тариалангийн загвар.....	40
Зураг 16: Баян-Өлгий аймгийн Үйлчилгээний динамик загвар.....	45
Зураг 17: Аж үйлдвэрлэлийн салбарын систем динамик загвар.....	54

### **Графикийн жагсаалт**

График 1: Аймгийн хүн амын хэтийн төлөв .....	3
График 2: Өлгий ба Сагсай сумын нийт хүн амын хэтийн төлөв .....	4
График 3: Ногооннуур сумын 6 настнууд ба Алтанцөгц сумын 28 настнуудын хэтийн төлөв .....	4
График 4: Баян-Өлгий аймагт шилжин ирсэн хүний тоо.....	4
График 5: Баян-Өлгий аймгаас шилжин явсан хүний тоо .....	5
График 6: Хүн амын шилжих хөдөлгөөний түүхэн тоо.....	<b>Error! Bookmark not defined.</b>
График 7: Шилжин ирж байгаа иргэд насны бүлгээр.....	10
График 8: Шилжин ирж байгаа иргэд Улаанбаатар хот, бусад аймгаар .....	11
График 9: Казакстан шилжиж байгаа иргэд насны бүлгээр.....	12
График 10: Шилжин явж байгаа иргэд насны бүлгээр .....	12
График 11: Шилжин явагсад Улаанбаатар хот, бусад аймгаар .....	13
График 12: Аймаг дотрох шилжих хөдөлгөөн сумаар.....	14
График 13: Наснаас хамаарсан төрөлтийн тархалт .....	23
График 14: Баян-Өлгий аймгийн нийт төрөлт ба Алтанцөгц сумын төрөлтийн хэтийн төлөв .....	24
График 15: Баян-Өлгий аймгийн нийт нас баралт ба Өлгий сумын нас баралт хүйсээр, насны ангиллаар.....	24
График 16: Баян-Өлгий аймгийн дундаж наслалт .....	25
График 17: Дундаж наслалт улсын дүнгээр .....	26
График 18: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	26
График 19 : Ажилгүй иргэдийг хүйсээр харьцуулахад .....	27
График 20: Насны бүлгээр харьцуулахад.....	27
График 21: Боловсролын түвшингээр ангилал .....	28
График 22: Боловсролын түвшингээр харьцуулсан байдал.....	28
График 23: Хөдөлмөр чадварын байдал .....	29
График 24: Нийт цэцэрлэгт хамрагдагсад сум сумаар .....	28

График 25: Бага боловсролын сурагчид.....	29
График 26: Дунд ангид элсэгчид .....	30
График 27: Сумдын бүрэн дунд боловсролын 12-р ангийн сурагчид .....	31
График 28: Нийт халдварт өвчнөөр өвчилсөн хүн ам.....	32
График 29: ХАА-н үйлдвэрлэл, тэрбумаар.....	33
График 30: ХАА-н үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь .....	33
График 31: ХАА-н үйлдвэрлэл ба нэг хүнд ногдох ДНБ .....	34
График 32: ХАА-н үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь .....	34
График 33: ХАА-н үйлдвэрлэл өсөлт Баруун 5 аймагт .....	34
График 34: Баян-Өлгий аймгийн нийт малын тоо толгой .....	35
График 35: Баян-Өлгий аймгийн нийт бод малын тоо толгой .....	35
График 36: Баян-Өлгий аймгийн нийт бог малын тоо толгой.....	35
График 37: Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэл .....	36
График 38: Мал аж ахуйн үйлдвэрлэл ХАА-н үйлдвэрлэлд эзлэх хувь.....	36
График 39: Баян-Өлгий аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл .....	36
График 40: Газар тариалангийн үйлдвэрлэл ХАА үйлдвэрлэлд эзлэх хувь .....	37
График 41: Газар тариалангийн үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь .....	37
График 42: Баян-Өлгий аймгийн нийт малын тоо толгойн хэтийн төлөв .....	38
График 43: Баян-Өлгий аймгийн малын тоо таван төрлөөр.....	39
График 44: Цэнгэл сумын малын тоо толгойн хэтийн төлөв .....	39
График 45: Баян-Өлгий аймгийн малын гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулах симуляцийн дараах мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл ба аймгийн 1 хүнд ноогдох ДНБ .....	40
График 46: Баян-Өлгий аймгийн Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл ба Бугат, Булган сумын төмсний ургацын хэмжээ .....	40
График 47: Баян-Өлгий аймгийн ХАА-н бусад салбараас олох орлого хэтийн төлөв .....	41
График 48: Баян-Өлгий аймгийн ХАА-н орлого хэтийн төлөв .....	42
График 49: Нийт ХАА-н ажил эрхлэлт .....	42
График 50: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэл ба ДНБ.....	43
График 51: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь .....	43
График 52: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын ажиллагсад.....	44
График 53: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь .....	44
График 54: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэлийн хэтийн төлөв .....	46
График 55: Баян-Өлгий аймгийн Үйлчилгээний салбарын ажиллах хүчний төлөв .....	46
График 56: Баян-Өлгий аймагт ирсэн жуулчид .....	47
График 57: Баян-Өлгий аймгийн жуулчдын хэтийн төлөв .....	47
График 58: Бүргэдийн баярт ирэх жуулчид .....	48
График 59: Баян-Өлгий аймгийн аялал жуулчалын салбарын орлого .....	48
График 60: Майхантай аялагчдын тооГрафик 61: Майхантай аялагчид .....	48
График 62 : Майхантай аялагчид.....	49
График 63: Баян-Өлгий аймгийн нийт үйлдвэрлэл /Сая төгрөг/ .....	50
График 64: Баруун 5 аймгийн аж үйлдвэрийн салбарын өсөлт 2010 оноос 2020 он хүртэл .....	51
График 65: Баруун 5 аймгийн аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2020 он.....	51
График 66: Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн хэтийн төлөв.....	54
График 67: Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн хэтийн төлөв, сумдаар.....	54
График 68: Баян-Өлгий аймгийн барилгын үйлдвэрлэл /сая.төгрөг/ .....	55
График 69: Баруун бүсийн барилгын салбарын өсөлт /сая.төгрөг/.....	55

График 70: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын ДНБ-д эзлэх хувь .....	55
График 71: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын хэтийн төлөв .....	56
График 72: Баян-Өлгий аймгийн барилгын салбар сумдаар .....	56
График 73: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын ажил эрхлэлтийн хэтийн төлөв .....	56
График 74: Баян-Өлгий аймгийн ДНБ .....	58
График 75: Баруун бүсийн аймгийн ДНБ-н өсөлт .....	58
График 76: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн бүтцийн хэтийн төлөв .....	58
График 77: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн хэтийн төлөв .....	59
График 78: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн хэтийн төлөв сумдаар .....	59
График 79: Ногооннуур сумын эдийн засгийн хэтийн төлөв сумдаар .....	59
График 80: Баян-Өлгий аймгийн нэг хүнд оногдох ДНБ .....	60
График 81: Улсын болон Баруун бүсийн нэг хүнд оногдох ДНБ .....	60
График 82: Баян-Өлгий аймгийн нэг хүнд ногдох ДНБ .....	60
График 83: Баян-Өлгий аймгийн нэг хүнд ногдох ДНБ сумаар .....	61
График 84: Ажил эрхлэлтийн түүхэн тоо .....	61
График 85: Ажиллах хүч сумаар .....	61
График 86: Ажиллах хүчнээс гадуурх иргэд .....	62
График 87: Баян-Өлгий аймгийн нийт ажил эрхлэлт .....	62
График 88: Аймгийн нийт ажилгүйдлийн түвшин .....	63
График 89: Ажилгүйдлийн түвшин сумаар .....	63
График 90: Нийт ажилгүй иргэд .....	64
График 91: Ажилгүй иргэд сумаар .....	64
График 92: Нийт жуулчид, симуляц .....	65
График 93: Нийт жуулчин симуляц .....	65
График 94: Нийт аялал жуулчлал дагасан ажил эрхлэлт, симуляц .....	66
График 95: Аймгийн аялал жуулчлал сумаар .....	66
График 96: Үйлчилгээний салбарын нийт ажил эрхлэлт, симуляц .....	67
График 97: Нийт ажилгүйдлийн түвшин, симуляц .....	67
График 98: Ажилгүйдлийн түвшин сумаар .....	67
График 99: Нийт амжил эрхлэлт, симуляц 2 .....	68
График 100: Нийт ажилгүйдлийн түвшин, симуляц 2 .....	68
График 101: Нийт арьс шир, симуляц 3 .....	69
График 102: Үнэгүйдсэн арьс ширний хэмжээ .....	69
График 103: Нийт боловсруулсан арьс, симуляц 3 .....	70
График 104: Арьс ширний үйлдвэрлэлийн ажил эрхлэлт .....	70
График 105: Хагас болон бүтэн боловсруулах үйлдвэрийн ажилчид сумаар .....	70
График 106: Нийт ноолуурын хэмжээ, симуляц 4 .....	71
График 107: Ноолуурын нийт орлого аймгаар, симуляц 4 .....	71
График 108: Ноолуурын нийт орлого аймгаар, симуляц 4 .....	71
График 109: Нийт ноосны хэмжээ, симуляц 5 .....	72
График 110: Ноосноос олох орлого, симуляц 5 .....	72
График 111: Нийт сарлагийн тоо, симуляц 6 .....	72
График 112: Нийт сарлагийн хөөврийн хэмжээ, симуляц 6 .....	73

### ***Хүснэгтийн жагсаалт***

Хүснэгт 1: Шилжин явалт аймгаар .....	5
Хүснэгт 2: Шилжин ирэлт аймгаар .....	6

Хүснэгт 3: Шилжих хөдөлгөөн статистик /1212.mn/.....	6
Хүснэгт 4: Шилжих хөдөлгөөний статистик /Аймгийн статистикийн хэлтэс/.....	7
Хүснэгт 5: Шилжих хөдөлгөөний статистик зөрүү бодсон /Аймгийн статистикийн хэлтэс/ ....	7
Хүснэгт 6: Шилжих хөдөлгөөн насаар.....	7
Хүснэгт 7: Шилжин ирэх хөдөлгөөн ялгаатай эх сурвалжаар .....	8
Хүснэгт 8: Шилжин явах хөдөлгөөн ялгаатай эх сурвалжаар .....	8
Хүснэгт 9: Шилжих хөдөлгөөн нэгдсэн дүнгээр.....	8
Хүснэгт 10: Шилжин ирсэн иргэдийн судалгаа насны бүлгээр.....	9
Хүснэгт 11: Шилжин ирж байгаа иргэд Улаанбаатар хот, бусад аймгаар .....	10
Хүснэгт 12: Шилжин явж байгаа иргэд насны бүлгээр.....	11
Хүснэгт 13: Шилжин явж байгаа хөдөлгөөн Улаанбаатар хот, бусад аймгуудаар.....	13
Хүснэгт 14: Баян-Өлгий аймгийн дотоод шилжих хөдөлгөөн .....	13
Хүснэгт 15: Аймаг дотрох шилжих хөдөлгөөн 2014-2021 оны нийлбэр дүнгээр .....	14
Хүснэгт 16: Сум хоорондын шилжих хөдөлгөөн болон ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан иргэдийн тоо .....	15
Хүснэгт 17: Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, хүйс .....	25
Хүснэгт 18: Баян-Өлгий аймгийн ажиллагчид, аймаг, хүйс .....	25
Хүснэгт 19: Ажилд зуучилсан хүний тоо	Хүснэгт 20: Ажил хайгч .....
Хүснэгт 21: Ажилгүй иргэдийг насны ангилалаар .....	27
Хүснэгт 22: Боловсролын түвшингээр .....	28
Хүснэгт 23: Алдарт эхийн одон, Насны хишиг.....	30
Хүснэгт 24: Халамжийн тэтгэвэр, Асаргааны тэтгэмж, Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж .....	25
Хүснэгт 25: Жирэмсэн эхийн тэтгэмж, Цалинтай ээж хөтөлбөр, Өрх толгойлсон.....	26
Хүснэгт 26: Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгаа.....	25
Хүснэгт 27: Аймгийн ДНБ болон Аж Үйлдвэрийн салбар .....	50

Товчилсон үгийн тайлбар

ХАА	Хөдөө аж ахуй
МАА	Мал аж ахуй
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ГАА	Говь-Алтай аймаг
БӨА	Баян-Өлгий аймаг
ХОА	Ховд аймаг
УВА	Увс аймаг
ЗАА	Завхан аймаг
ӨВА	Өвөрхангай аймаг
АРА	Архангай аймаг
ХӨА	Хөвсгөл аймаг
БНА	Баянхонгор аймаг
БУА	Булган аймаг
ОРА	Орхон-Уул аймаг
ДГА	Дорноговь аймаг
ДУА	Дундговь аймаг
ӨМА	Өмнөговь аймаг
СЭА	Сэлэнгэ аймаг
ТӨА	Төв аймаг
ДАА	Дархан-Уул аймаг
ГСА	Говьсүмбэр аймаг
ДОА	Дорнод аймаг
СБА	Сүхбаатар аймаг
ХЭА	Хэнтий аймаг
УБА	Улаанбаатар хот



## УДИРТГАЛ

Уг судалгаанд Баян-Өлгий аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны үндсэн үзүүлэлтүүд, эдгээрийн 2030 он хүртэлх хэтийн төсөөлөл, хөгжил дэвшил, аймаг, сум суурингуудын хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, ядуурал, хөдөлмөр эрхлэлт гэх мэт олон хүчин зүйлийг авч үзэж, янз бүрийн бодлого, төлөвлөлт нь эргээд нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгааг загварчилсан болно.

Баян-Өлгий нь байгалийн унаган төрхөө хадгалсан, нутаг дэвсгэр нь мөнх цаст сүрлэг өндөр уулс, алт, ховор ан амьтан ургамал, мөнгө, гянтболд, төмрийн хүдэр, зэс, хар тугалга, нүүрс зэрэг эрдэс баялагийн арвин их нөөцтэй, уул уурхайн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, улс дамнасан худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх боломжтой аймаг юм.


Аялал жуулчлал болон Худалдаа үйлчилгээ, Хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх боломжтой.

ХАА-н салбар нь байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах, үүлдэр угсаа, ашиг шимийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлох, тариалангийн талбайг нөхөн сэргээх, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, өрхийн тариаланг хөгжүүлэх зорилттой.

Цагааннуур болон Даянгийн боомтыг аймгийн төвтэй хатуу хучилттай автозамаар холбож, тээвэр логистикийн төв барьж, эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлснээр тус аймагт худалдааны салбар, аялал жуулчлалыг дагасан үйлчилгээний салбар хөгжих бүрэн боломжтой.

Аймгийн төвийн нисэх онгоцны буудлыг шинэчлэн сайжруулж, олон улсын нисэх буудлын зэрэглэлтэй болгох, аялал жуулчлалын маршрутыг гаргах, Алтай таванбогд чиглэлийн хатуу хучилттай автозамыг барих, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн зочид буудал, жуулчны баазуудыг барьж байгуулснаар аялал жуулчлал эрчимтэй хөгжинө.

Асгатын мөнгөний ордыг ашиглах, эргэлтэнд оруулснаар аймгийн эдийн засаг эрчимжин, төрөлжиж ажилгүйдэл, ядуурлын түвшин буурах боломжтой болох нь бидний боловсруулан гаргасан системийн динамик загвар дээр харагдсан.





## **СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ**

- Энэхүү судалгаанд орчин үеийн математик загварчлалын дифференциал тэгшитгэл, корреляци, регрессийн томъёо, арга аргачлалыг ашигласан.
- Системийн динамик загварчлал, симуляцийн туршилт, үр дүнг ажиглах, харьцуулах, загварын параметруудад анализ хийх, үр дүнг тооцох ажлыг “Vensim”, “Matlab” програм ашиглан хийж гүйцэтгэсэн.
- Загварын үр дүнг харуулах, тоон өгөгдөл болон тэгшитгэл, томъёонуудыг харьцуулахад график дизайны аргыг ашигласан.
- Загварыг боловсруулахад 47 сектор, 5000 гаруй хувьсагч параметр, 40 гаруй ердийн дифференциал тэгшитгэлүүд, 30 орчим регрессийн тэгшитгэл зохиогдсон бөгөөд “Рунге-Кутта”-ийн тоон аргаар бодож, шийдлийг гаргасан.

## **Үр дүн**



- Аймгийн *нийгэм, эдийн засаг, байгаль орчны* үндсэн үзүүлэлтүүд болох 80 орчим үзүүлэлтээр “Vensim” програм дээр тус аймгийн стратеги, хөгжлийн динамик загвар боловсруулж хүлээлгэж өгснөөр хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн зохистой түвшин, зүй зохистой хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний янз бүрийн бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлэх, төлөвлөх боломж бүрдэнэ.
- Хүн амын хэсэгт тус аймгийн төрөлт, нас баралт, дотоод болон гадаад шилжилт хөдөлгөөний 2010 оноос 2020 оны тоон мэдээллүүдийг ашиглан, хүн амын ирээдүйн өсөлт, хэтийн төлвийг тусгайлан авч үзэж загварчилсан.
- Загварчлалд хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх гол хүчин зүйлсээр аймаг ба сумдын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, мөн зөөлөн болон хатуу дэд бүтцийн таталцлыг тооцоолсон. Мөн үндэстэн ястаны онцлогоос хамаарсан шилжилт хөдөлгөөнийг бусад аймаг, хотод орших казак үндэстний тооноос хамааруулж авч үзсэн.
- Аймаг ба сумдын ДНБ-ий хэмжээ, эдийн засгийн төрөлжилт, зам дэд бүтэц, хилийн боомт, хүн амын ёс заншил, соёлын болон байгаль, цаг уурын онцлогоос хамаарсан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудлыг мөн онцгойлон авч үзсэн.





Баян-Өлгий бүх сумуудын хүн ам [Баян-Өлгий] : current | Сагсай бүх сумуудын хүн ам [Сагсай] : current

**График 2: Өлгий ба Сагсай сумын нийт хүн амын хэтийн төлөв**



Баян-Өлгий аймаг хүн ам [Баян-Өлгий, Ногооннуур, Эмэгтэй, Нас 6] : current | Баян-Өлгий аймаг хүн ам [Баян-Өлгий, Ногооннуур, Эрэгтэй, Нас 6] : current | Баян-Өлгий аймаг хүн ам [Баян-Өлгий, Алтанцөгц, Эмэгтэй, Нас 28] : current | Баян-Өлгий аймаг хүн ам [Баян-Өлгий, Алтанцөгц, Эрэгтэй, Нас 28] : current

**График 3: Ногооннуур сумын 6 настнууд ба Алтанцөгц сумын 28 настнуудын хэтийн төлөв**

### ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Баян-Өлгий аймгийн дотоод шилжилт хөдөлгөөн дээр анализ хийж үзвэл тус аймгаас шилжин явж буй хүн амын тоо бага зэрэг өсөх хандлагатай байгаа бол шилжин ирэх хүн амын тоо тогтвортой байхаар харагдаж байна.



**График 4: Баян-Өлгий аймагт шилжин ирсэн хүний тоо**



График 5: Баян-Өлгий аймгаас шилжин явсан хүний тоо

### Шилжин явалт

#### Хүснэгт 1: Шилжин явалт аймгаар

	1990-1999 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж явсан тоо		2000-2009 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж явсан тоо		2010-2019 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж явсан тоо	
	Аймг	Тоо	Аймг	Тоо	Аймг	Тоо
1	Баян-Өлгий	62.67	Төв	48.32	Говьсүмбэр	38.15
2	Говьсүмбэр	48.36	Говьсүмбэр	41.65	Орхон	31.50
3	Дорноговь	40.90	Увс	39.90	Дархан-Уул	30.89
4	Дорнод	37.37	Завхан	39.84	Төв	30.58
5	Төв	36.35	Дархан-Уул	34.57	Дундговь	29.20
6	Увс	34.45	Дундговь	33.07	Завхан	28.98
7	Өмнөговь	33.87	Орхон	30.50	Сэлэнгэ	27.85
8	Дархан-Уул	31.22	Говь-Алтай	29.34	Булган	26.41
9	Булган	30.90	Сэлэнгэ	28.12	Хэнтий	24.79
10	Завхан	29.39	Архангай	25.66	Говь-Алтай	23.05
11	Архангай	28.72	Булган	25.65	Дорноговь	22.71
12	Хэнтий	28.48	Дорнод	25.50	Увс	21.37
13	Говь-Алтай	27.84	Хэнтий	25.21	Ховд	20.96
14	Сэлэнгэ	25.68	Баянхонгор	23.99	Өвөрхангай	19.73
15	Хөвсгөл	22.70	Ховд	23.93	Архангай	18.20
16	Баянхонгор	19.81	Сүхбаатар	22.12	Дорнод	17.81
17	Дундговь	19.69	Дорноговь	20.91	Баянхонгор	16.68
18	Орхон	19.62	Өмнөговь	19.06	Өмнөговь	16.39
19	Ховд	18.62	Өвөрхангай	18.83	Сүхбаатар	15.53
20	Өвөрхангай	17.35	Хөвсгөл	16.20	Хөвсгөл	14.36
21	Сүхбаатар	17.26	Баян-Өлгий	14.57	Баян-Өлгий	10.93
22	Улаанбаатар	7.04	Улаанбаатар	4.69	Улаанбаатар	7.62

### Шилжин ирэлт

**Хүснэгт 2: Шилжин ирэлт аймгаар**

	1990-1999 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж ирсэн тоо		2000-2009 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж ирсэн тоо		2010-2019 оны аймгуудын 1000 хүнд ноогдох шилжиж ирсэн тоо	
1	Говьсүмбэр	47.78	Говьсүмбэр	39.09	Говьсүмбэр	44.18
2	Орхон	46.39	Орхон	32.56	Дархан-Уул	26.53
3	Дорноговь	38.77	Дархан-Уул	30.38	Орхон	26.27
4	Булган	31.17	Улаанбаатар	29.57	Сэлэнгэ	25.42
5	Дархан-Уул	27.16	Дорноговь	19.61	Дорноговь	24.33
6	Баян-Өлгий	26.36	Төв	19.10	Төв	24.28
7	Өмнөговь	24.16	Сэлэнгэ	16.68	Өмнөговь	23.05
8	Завхан	22.82	Булган	11.04	Булган	19.72
9	Хөвсгөл	22.03	Хэнтий	10.07	Хэнтий	18.64
10	Төв	21.15	Өмнөговь	9.38	Улаанбаатар	17.03
11	Хэнтий	19.58	Завхан	8.62	Дундговь	14.76
12	Улаанбаатар	18.98	Баянхонгор	7.02	Завхан	12.34
13	Архангай	18.62	Дорнод	6.64	Ховд	11.58
14	Сэлэнгэ	18.58	Дундговь	6.29	Сүхбаатар	11.14
15	Дундговь	17.65	Ховд	6.02	Дорнод	10.95
16	Говь-Алтай	17.57	Говь-Алтай	5.49	Увс	8.28
17	Өвөрхангай	16.33	Өвөрхангай	5.32	Говь-Алтай	7.99
18	Сүхбаатар	15.56	Увс	4.57	Архангай	7.83
19	Дорнод	14.60	Хөвсгөл	4.30	Баянхонгор	7.66
20	Баянхонгор	13.40	Архангай	3.94	Хөвсгөл	7.21
21	Увс	13.05	Сүхбаатар	3.48	Өвөрхангай	7.17
22	Ховд	11.79	Баян-Өлгий	2.59	Баян-Өлгий	1.98

**Шилжилт хөдөлгөөний дүн шинжилгээ**

Баян-Өлгий аймгийн шилжих хөдөлгөөнд дүн шинжилгээ хийхдээ Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сан /1212.mn/, Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн газрын мэдээ, Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэсийн мэдээ, Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын статистик мэдээ зэрэгт үндэслэсэн болно.

Эдгээр эх сурвалжуудын статистик, тоон мэдээ зөрүүтэй байгаа бөгөөд энэ нь цаашид хийх судалгааны ажилд хугацаа алдах гэх мэт хүндрэл бэрхшээл учруулж байна.

Статистик, тоон мэдээллийг эх сурвалжаар нь авч үзье. Үүнээс:

**Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээ /1212.mn/**

**Хүснэгт 3: Шилжих хөдөлгөөн статистик /1212.mn/**

Баян-Өлгий аймаг	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Бүгд	88,183	88,772	90,511	92,454	95,151	100,189	100,172	102,604	105,090	108,530	110,597	112,836
Шилжин ирсэн	80	74	105	233	218	262	270	317	214	154	163	206
Шилжин явсан	2,721	1,383	292	615	695	1,328	2,570	353	199	460		

#### Хүснэгт 4: Шилжих хөдөлгөөний статистик /Аймгийн статистикийн хэлтэс/

Шилжих хөдөлгөөн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шилжин ирэгсэд бүгд	22	74	95	233	218	262	270	317	214	154	163
Үүнээс: Казахстанас											
Шилжин явагсад бүгд	2721	1383	862	614	695	1328	2570	353	199	460	634
Үүнээс: Казахстан	2203	918	567	103	216	822	2124	405			

Дээрх хоёр эх сурвалжийн статистик мэдээг харахад 2012 оны шилжин явсан хүн амын тоо зөрүүтэй байна. Мөн 2017 оны Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтсийн мэдээнд нийт шилжин явагсад 353 ба үүнээс 405 хүн Казакстан улсруу шилжсэн гэсэн тоон мэдээ байна.

#### Хүснэгт 5: Шилжих хөдөлгөөний статистик зөрүү бодсон /Аймгийн статистикийн хэлтэс/

Шилжих хөдөлгөөн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шилжин ирэгсэд бүгд	22	74	95	233	218	262	270	317	214	154	163
Үүнээс: Казахстанас											
Шилжин явагсад бүгд	2721	1383	862	614	695	1328	2570	353	199	460	634
Казакстанлуу	2203	918	567	103	216	822	2124	405			
Үүнээс: Улаанбаатар хот, бусад аймаг	518	465	295	511	479	506	446	-52	199	460	634

2012 оны зөрүүтэй тоон мэдээнд дүн шинжилгээ хийж нийт шилжин явагсад нь 862 үүнээс Казакстан улсруу **567** шилжсэн бөгөөд үлдсэн **295** иргэн бусад аймаг, хотруу шилжсэн гэж дүгнэж болохоор байна. Мөн 2017 оны тоон мэдээлэл дээр нийт шилжин явагсад нь 758 бөгөөд үүнээс Казакстан улсруу шилжсэн нь **405**, бусад аймаг, хотруу шилжсэн нь 353 гэж тооцлоо. 1212.mn дээрх 2012, 2017, 2018, 2019 онуудын тоон мэдээ нь зөвхөн Монгол Улсын хэмжээнд шилжин явсан статистик тоо гэж харж болохоор байна. 2017 оноос хойш хоёр эх сурвалжийн тоон мэдээн дээр Казакстан улсруу шилжсэн мэдээлэл байхгүй байна.

#### Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн газрын мэдээ

##### Хүснэгт 6: Шилжих хөдөлгөөн насаар

Шилжин хөдөлгөөн	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Аймгаас хотоос бүрмөсөн шилжин ирсэн	101	255	181	262	270	284	267	135	164	209
Үүнээс: Насанд хүрэгч	75	194	148	187	207	218	211	99	123	133
Хүүхэд/16 аас доош насны/	26	61	33	75	63	66	56	36	41	76
Аймгаас хотоос бүр мөсөн шилжин явсан	237	511	474	542	352					

Үүнээс	Насанд хүрэгч	172	418	407	490	306						
	Хүүхэд/16 аас доош насны/	65	93	67	88	46						

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн газрын статистикт шилжилт хөдөлгөөнд орсон иргэдийг насны ангилалаар нь бүртгэлжүүлсэн тоон мэдээлэл байгаа ч нөгөө хоёр эх сурвалжаас мөн л зөрүүтэй байна.

Баян-Өлгий аймагт шилжин ирсэн иргэдийн тоо/3-н эх сурвалжаас/

**Хүснэгт 7: Шилжин ирэх хөдөлгөөн ялгаатай эх сурвалжаар**

Шилжин ирсэн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
1212.mn	80	74	105	233	218	262	270	317	214	154	163	206
Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс	22	74	95	233	218	262	270	317	214	154	163	
Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар			101	255	181	262	270	284	267	135	164	209

Баян-Өлгий аймгаас шилжин явсан иргэдийн тоо/3-н эх сурвалжаас/

**Хүснэгт 8: Шилжин явах хөдөлгөөн ялгаатай эх сурвалжаар**

Шилжин явсан	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
1212.mn	2,721	1,383	292	615	695	1,328	2,570	353	199	460	
Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс	2721	1383	862	614	695	1328	2570	353	199	460	634
Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар			237	511	474	542	352				

Дээрх эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж үзээд Баян-Өлгий аймгийн шилжих хөдөлгөөний статистик мэдээг 1212.mn сангийн мэдээллийг голлон баримталж түүхэн тоог дараах байдлаар сонголоо.


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН**

**Хүснэгт 9: Шилжих хөдөлгөөн нэгдсэн дүнгээр**

Шилжих хөдөлгөөн	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Шилжин ирэгсэд бүгд	22	74	95	233	218	262	270	317	214	154	163
Үүнээс: Казакстанаас											
Шилжин явагсад бүгд	2721	1383	862	614	695	1328	2570	758	199	460	634
Үүнээс: Казакстан	2203	918	567	103	216	822	2124	405			
Үүнээс: Улаанбаатар хот, бусад аймаг	518	465	295	511	479	506	446	353	199	460	634

Дээрх тоон мэдээнээс дүгнэхэд жилд дунджаар аймгийн хүн амын 1.16 хувь нь шилжин явах хөдөлгөөнд, 0.19 хувь нь шилжин ирэх хөдөлгөөнд орсон байгаагаас шилжин явах хөдөлгөөн нь шилжин ирэх хөдөлгөөнөөс 6.11 дахин их байна. 2010-2017 оны тоон мэдээг харахад нийт шилжин явж байгаа иргэдийн 57.4 хувь нь Казакстан улс руу шилжиж байна.





*Лүндэсний статистикийн хороо 1212.mn, Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*

### **Баян-Өлгий аймагт шилжин ирж байгаа иргэд:**

Шилжилт хөдөлгөөнд орсон иргэдийн судалгааг насны бүлгээр нь аймгийн статистикийн хэлтэс болон улсын бүртгэлийн ерөнхий газраас гарсан байна.


Шилжин ирсэн иргэдийн тоо насны бүлгээр /Гурван эх үүсвэрээс/

#### **Хүснэгт 10: Шилжин ирсэн иргэдийн судалгаа насны бүлгээр**

Шилжин ирэгсэд насны бүлгээр		2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Статистикийн хэлтэс	Бүгд				<b>262</b>	<b>270</b>	<b>317</b>	<b>214</b>	<b>154</b>	<b>163</b>	
	Насанд хүрсэн 0-14 нас				177	206	236	163	113	121	
					85	64	81	51	41	42	
Улсын бүртгэлийн газар	Бүгд	<b>101</b>	<b>255</b>	<b>181</b>	<b>262</b>	<b>270</b>	<b>284</b>	<b>267</b>	<b>135</b>	<b>164</b>	<b>209</b>
	Насанд хүрсэн 16-аас доош	75	194	148	187	207	218	211	99	123	133
		26	61	33	75	63	66	56	36	41	76
1212.mn	Бүгд	<b>105</b>	<b>233</b>	<b>218</b>	<b>262</b>	<b>270</b>	<b>317</b>	<b>214</b>	<b>154</b>	<b>163</b>	<b>206</b>

Дээрх хүснэгтээс харахад гурван эх үүсвэрийн тоон мэдээ байнга зэрэг зөрүүтэй байгаа ч 1212.mn сангийн тоон мэдээтэй, аймгийн статистикийн тоон мэдээ тохирч байна.

Аймгийн статистик мэдээнд дүн шинжилгээ хийхэд Баян-Өлгий аймагт шилжин ирж байгаа иргэдийн 26.3 хувь нь 0-14 насныхан, 42.1 хувь нь 15-29 насныхан, 24.5 хувь нь 30-54 насныхан, 7 хувь нь 55-аас дээш насныхан эзэлж байна. 15-29 насныхны шилжин ирэлт сүүлийн жилүүдэд 0.12 хувиар буурч байгаа бол 30-54 насныхан 0.08 хувиар өссөн дүнтэй байна.



**График 6: Шилжин ирж байгаа иргэд насны бүлгээр**

*Лүндэсний статистикийн хороо 1212.тп, Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*

Шилжин ирсэн иргэдийн байршлаас нь хамааруулж үзвэл 46.1 хувийг Улаанбаатар хотоос, 26 хувийг Ховд аймгаас, 8.4 хувийг Увс аймгаас, үлдсэн 19.5 хувийг бусад аймгууд эзэлж байна.

**Хүснэгт 11: Шилжин ирж байгаа иргэд Улаанбаатар хот, бусад аймгаар**

Шилжиж ирсэн	2016	2017	2018	2020
Улаанбаатар	133	162	64	88
Ховд	68	72	78	32
Увс	33	15	20	12
Дархан-Уул		13	15	
Орхон	8	13	6	11
Сэлэнгэ	9		16	
Говь-Алтай				5
Дорноговь				4
Төв		12		
Завхан		10	5	3
Өмнөговь				3
Бусад	19	20	10	5

2017 онд Улаанбаатар хотоос 162 хүн шилжин ирж байсан бол 2018 онд 64 болж буурсан боловч 2020 онд 88 хүрч 24 хүнээр өссөн байна. Харин Ховд аймгаас 2017, 2018 онуудад 70 гаран хүн шилжиж ирж байсан бол 2020 онд 32 болж буурсан байна.




График 7: Шилжин ирж байгаа иргэд Улаанбаатар хот, бусад аймгаар

/ Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/


### Баян-Өлгий аймгаас шилжин явж байгаа иргэд:

Шилжин явагсдийн статистик мэдээг насны ангиллаар нь хоёр эх сурвалжаар авч 1212.мн-ны дүнтэй тулгахад 2012, 2013, 2014, 2015 оны аймгийн статистикийн мэдээ нь Казакстан шилжсэн иргэдийн тоотой тэнцэж байгаа бол аймгийн улсын бүртгэлийн газраас авсан тоо Монгол улсын бусад аймаг руу шилжсэн тоотой тэнцэж байна. 2016, 2017, 2018, 2019 оны аймгийн статистикийн мэдээ нь 1212.мн сангийн мэдээтэй таарч байна.

### Хүснэгт 12: Шилжин явж байгаа иргэд насны бүлгээр

Шилжин явагсад насны бүлгээр		2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Статистикийн хэлтэс	Бүгд	567	103	216	743	446	353	199	460	
	Насанд хүрсэн 0-14 нас	515	85	196	707	371	274	155	302	
		52	18	20	36	75	79	44	158	
Улсын бүртгэлийн газар	Бүгд	237	511	474	542	352				
	Насанд хүрсэн 16-аас доош	172	418	407	490	306				
		65	93	67	88	46				
1212.мн – ээс тооцсон	Бүгд	862	614	695	1328	2570	758	199	460	634
	Казакстан	567	103	216	822	2124	405			
	Улаанбаатар хот, бусад аймаг	295	511	479	506	446	353	199	460	634


2012 онд Казакстан шилжиж байгаа иргэдийн 68 хувийг 15-29 насныхан, 20.1 хувийг 30-54 насныхан эзэлж байсан бол бол 2015 онд 30 хувийг 15-29 насныхан, 50 хувийг 30-54 насныхан эзэлж байна.



**График 8: Казакстан шилжиж байгаа иргэд насны бүлгээр**

*/Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*

Монгол Улс доторх шилжих хөдөлгөөнд 2016 онд шилжин явагсдын 62.8 хувь нь 15-29 насныхан, 16 хувь нь 30-54 насныхан байсан бол 2019 онд 34.3 хувийг 0-14 насныхан, 25.2 хувийг 15-29 насныхан, 24.3 хувийг 30-54 насныхан эзэлж байна.



**График 9: Шилжин явж байгаа иргэд насны бүлгээр**


*/Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*

Шилжин явж байгаа иргэдийн 41.1 хувь нь Улаанбаатар хот, 28.5 хувь нь Ховд аймаг, 8.2 хувь нь Увс аймаг, 22.2 хувь бусад аймаг руу шилжиж байна.

**Хүснэгт 13: Шилжин явж байгаа хөдөлгөөн Улаанбаатар хот, бусад аймгуудаар**

Шилжин явсан	Улаанбаатар	Ховд	Увс	Дархан-Уул	Орхон	Сэлэнгэ	Бусад	Бүгд
2016	298	92	18			10	28	446
2017	97	92	48	37	17	20	42	353
2018	58	77	14	17	6	16	11	199

*/Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*



**График 10: Шилжин явагсад Улаанбаатар хот, бусад аймгаар**

*/Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс/*

**Баян-Өлгий аймаг доторх шилжих хөдөлгөөн**

Баян-Өлгий аймгийн аймаг доторх шилжих хөдөлгөөнийг авч үзвэл нийт хүн амын 3.4 хувь сум хооронд, 2.2 хувь нь баг хооронд шижих хөдөлгөөнд орж байна.

**Хүснэгт 14: Баян-Өлгий аймгийн дотоод шилжих хөдөлгөөн**

Шилжин ирсэн	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	
Хот доторх шилжилт хөдөлгөөн	2823	1451	6043	4354	7404	3401	2449	1522	3261	1759	
Үүнээс:	суманд шилжин ирсэн	873	1300	1283	1153	2336	1858	1347	799	918	
	Үүнээс	насанд хүрэгч	834	1070	1037	959	2081	1627	1029	604	635
		Хүүхэд/16 аас доош насны/	39	230	246	194	255	231	318	195	283
	Багт шилжин ирсэн	1950	151	4760	3201	5068	1543	1102	723	2406	841
	Үүнээс	насанд хүрэгч	1936	419	3243	2173	4087	1220	819	475	1521

	Хүүхэд/16 аас доош насны/	14	98	1517	828	981	323	283	248	885	323
--	---------------------------	----	----	------	-----	-----	-----	-----	-----	-----	-----

/Эх сургавалж: Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар/

Сум хооронд шилжих хөдөлгөөнийг харвал 2016 онд хамгийн өндөр буюу 2336 хүрсэн байна. Үүний шалтгаан нөхцлийг тодруулах шаардлагатай байна. 2021 оны байдлаар 918 хүн сум хооронд шилжих хөдөлгөөнд орсон мэдээ байна.

2014 оноос хойш Баян-Өлгий аймаг дотроо 10549 хүн шилжих хөдөлгөөнд оролцсоноос 3302 хүн ажил хайж буй шалтгаанаар шилжсэн бөгөөд эдгээр иргэдийн 75 хувь нь Өлгий сум буюу аймгийн төвд суурьшсан байна. Бусад сумдаас Ногооннуур суманд шилжин ирэгсэд их бүртгэгдсэн ба эдгээрээс ажил хайж шилжин суурьшсан 123 иргэн байна. Цагааннуур суманд хамгийн бага шилжин ирэгсэд бүртгэгдсэн бөгөөд ажил хайж шилжин суурьшсан 3 иргэн байна.




График 11: Аймаг доторх шилжих хөдөлгөөн сумаар

Хүснэгт 15: Аймаг доторх шилжих хөдөлгөөн 2014-2021 оны нийлбэр дүнгээр

№	Сум	2014-2021 он	
		Нийт шилжин ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан
1	Ногооннуур	460	123
2	Цэнгэл	360	101
3	Баяннуур	338	72
4	Улаанхус	303	85
5	Дэлүүн	256	66
6	Сагсай	253	78
7	Буянт	248	61
8	Булган	227	57
9	Бугат	203	60
10	Толбо	179	51

11	<i>Алтанцөгц</i>	134	31
12	<i>Алтай</i>	82	25
13	<i>Цагааннуур</i>	10	3
14	<i>Өлгий</i>	7495	2489
<b>Баян-Өлгий</b>		<b>10549</b>	<b>3302</b>

Нийт шилжин ирсэн, түүнээс ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан хүн амын тоог оноор болон Баян-Өлгий аймгийн сумдаар гаргасныг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 16: Сум хоорондын шилжих хөдөлгөөн болон ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан иргэдийн тоо

№	Баян-Өлгий аймгийн сумууд	2014		2015		2016		2017		2018		2019		2020		2021	
		Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан	Нийт ирсэн	Ажил хайж буй шалтгаанаар шилжин суурьшсан
1	Алтай	0	0	17	11	35	5	10	2	0	0	4	3	7	2	9	2
2	Алтанцөгц	0	0	8	5	55	8	10	2	14	5	1	1	3	1	42	9
3	Баяннуур	5	1	5	3	187	27	60	12	55	19	6	5	7	2	14	3
4	Бугат	0	0	14	9	28	4	55	11	32	11	8	7	47	14	19	4
5	Булган	91	20	35	22	97	14	0	0	0	0	0	0	0	0	5	1
6	Буянт	9	2	35	22	125	18	10	2	14	5	0	0	3	1	51	11
7	Дэлүүн	50	11	14	9	62	9	35	7	43	15	1	1	40	12	9	2
8	Ногооннуур	41	9	32	20	159	23	81	16	84	29	17	14	23	7	23	5
9	Сагсай	45	10	36	23	55	8	10	2	61	21	5	4	17	5	23	5
10	Толбо	27	6	14	9	21	3	0	0	12	4	5	4	40	12	61	13
11	Улаанхус	18	4	24	15	118	17	70	14	0	0	26	22	37	11	9	2
12	Цагааннуур	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	10	3	0	0
13	Цэнгэл	86	19	43	27	49	7	121	24	3	1	13	11	27	8	19	4
14	Өлгий	910	200	877	555	1345	194	1395	277	1030	357	712	593	593	177	634	136
15	<b>Баян-Өлгий</b>	<b>1283</b>	<b>282</b>	<b>1153</b>	<b>730</b>	<b>2336</b>	<b>337</b>	<b>1858</b>	<b>369</b>	<b>1347</b>	<b>467</b>	<b>799</b>	<b>665</b>	<b>855</b>	<b>255</b>	<b>918</b>	<b>197</b>

/Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн газар/



Монгол улсын нийт хүн амын 3.9%-ийг Казак үндэстэн эзэлж байна. Баян-Өлгий аймгийн шилжилт хөдөлгөөнд ажилгүйдэл, ядуурал, ажлын байр нөлөөлөхөөс гадна Казак үндэстний онцлог нөлөөлөх хандлагатай байна. Энэ нь бусад аймаг орон нутагт байгаа казах иргэдийн тоотой холбоотой болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл тус орон нутагт казах иргэдийн тоо олон бол Баян-Өлгий аймгаас иргэд тэр орон нутагт их шилжин ирж байна. Тус орон нутагт казах иргэд суурьшаагүй бол Баян-Өлгий аймгаас тус аймагт иргэд бараг шилшин суурьшихгүй байгаа төлөв ажиглагдаж байна. Өөрөөр 2030 он гэхэд Баян-Өлгий аймгаас бусад хот суурин газарт оршин суух Казак үндэстний тоо 50 мянгад хүрэх боломжтой.

Баян-Өлгий аймгийн шилжин явах хөдөлгөөн тус аймгийн ядуурлын түвшинтэй хамгийн өндөр буюу 73% (R=73) хувийн хамааралтай гарсан бөгөөд ажилгүйдлийн түвшингөөс 39% (R=39) хамаарч байна.

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Ажилгүйдэл	27.9	28.8	19.9	20.0	19.8	25.6	7.4	8.2	8.2	18.9
Шилжилт	<b>2721</b>	<b>1383</b>	<b>862</b>	<b>614</b>	<b>695</b>	<b>1328</b>	<b>2580</b>	<b>353</b>	<b>199</b>	<b>460</b>

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Ядуурал	0.39	0.34	0.27	0.25	0.22	0.28	0.34	0.29	0.24	0.33
Шилжилт	<b>2721</b>	<b>1383</b>	<b>862</b>	<b>614</b>	<b>695</b>	<b>1328</b>	<b>2580</b>	<b>353</b>	<b>199</b>	<b>460</b>

Баян-Өлгий аймгийн шилжилт хөдөлгөөн 2026 он хүртэл нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд аймгийн эдийн засгийн өсөлт, ядуурлын түвшингийн бууралтаас хамаарч 2027 оноос шилжилт буурах төлөвтэй байна.



## Гадаад шилжих хөдөлгөөн

Какастан улсад 2019 оны байдлаар 8000 орчим Монгол улсын иргэд оршин суудаг бол Казакстан улсын 492 иргэн Монгол улсад оршин суудаг байна.

Баян-Өлгий аймгийн иргэдийн шилжил хөдөлгөөн 1991 оноос идэхитэй нэмэгдсэн бөгөөд 1991-1993 оны хооронд хөдөлмөрийн гэрээгээр 12257 өрхийн 60 орчим мянган (үүнээс 20 гаруй мянга нь хөдөлмөрийн чадвартай) иргэн Монгол Улсаас БНКаЗУ-д шилжин суурьшсан гэх албан мэдээ байдаг. Мөн албан бус мэдээгээр, 1991-2018 оны хооронд Монгол Улсын нийт 100 орчим мянган казах иргэд БНКаЗУ-д шилжин суурьшсан байна.


Харин 2010-2019 онд Монгол Улсаас казах иргэд гэр бүлээр шилжин явах явдал багасаж, түр хугацаагаар хөдөлмөр эрхлэх, ганц бие хөдөлмөрийн насныхан болон их дээд сургуульд сурч боловсрох сонирхолтой оюутан залуус голлон шилжилт хөдөлгөөнд оролцох үйл явц ажиглагдаж байна. Түр хугацаагаар шилжигчид нь Монгол Улсад үлдсэн ар гэрийхэндээ мөнгө илгээж байгаа нь өрх гэрийн орлогыг хангах нэг гол үүсвэр болж байна. БНКаЗУ их дээд сургуульд суралцагчдад үнэгүй боловсрол олгодог тул Монгол Улсаас казах оюутнууд их дээд сургуульд суралцахын тулд БНКаЗУ-ыг зорих, оюутнууд нэмэгдсэн байна.

*Эх сурвалж: Казахстан улсын угсаатны шилжилт хөдөлгөөний бодлого, түүний үр дүн/Эрдэм шинжилгээний ажилтан Шугатайн Амангүл, магистр ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн Улаанбаатар, Монгол/*

2011-2016 оны хооронд Баян-Өлгий аймгаас шилжиж байгаа иргэдийн 50%-с илүү хувь нь гадаад шилжилт буюу Казакстан улс руу шилжсэн байна. Казакстан улс руу шилжигчдийн тоо 2017 оноос буурсан бөгөөд энэ тоо цаашид ч буурах төлөвтэй байна.

2016 онд 2124 иргэн Баян-Өлгий аймгаас Казакстан улсруу шилжсэн нь сүүлийн 12 жилийн хугацаанд хамгийн өндөр шилжилт болсон байна. 2022 оноос эхлэн Баян-Өлгий аймгаас жилд дунджаар 450 орчим иргэд Казакстан улсруу шилжих хандлагатай байна. Казакстан улсруу чиглэсэн шилжилтэнд тус улсын Нэг хүнд оногдох ДНБ-ын өсөлт 36% нөлөө үзүүлж байна.

Үүнээс Каказстан улсруу шилжих хөдөлгөөн




## Дотоод шилжих хөдөлгөөн

Баян-Өлгий аймгаас шилжин явагсдын шилжилтийн чиглэл нь Улаанбаатар хот болон Ховд аймагт өндөр байгаа бөгөөд бусад аймаг хотууд руу чиглэсэн хөдөлгөөн харьцангуй бага байна. Шилжилт хөдөлгөөнийг 1000 хүнд оногдохоор тооцоход Ховд

аймаг руу шилжих хөдөлгөөн хамгийн өндөр байна. 2010-2018 онуудад Баян-Өлгий аймгаас шилжих дотоод шилжих хөдөлгөөн буурсан боловч 2019 оноос 2026 он хүртэл нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нь бусад аймгуудын нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн Баян-Өлгий аймгаас их байгаа учраас таталцал явагдаж буйтай холбоотой.

Дотоод шилжих хөдөлгөөн



Баян-Өлгий аймгаас Улаанбаатар хотод шилжилт хийж байгаа иргэдийн тоо нь тус хотод оршин суугаа Казак үндэстний тоотой хамааралтай байна.

Улаанбаатар хотод буй казак иргэдийн тоо хамгийн өндөр буюу нийт иргэдийн 0.25%-тай тэнцүү байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ тоо 0.5% хүртэл нэмэгдэх төлөвтэй. 2022-2030 онд дунджаар 197 иргэн Баян-Өлгий аймгаас Улаанбаатар хот руу шилжих төлөвтэй байна.

2026 оноос 2028 он хүртэл Улаанбаатар хотруу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурах бөгөөд 2028 оноос хойш тогворжиж жилд 181 орчим хүн шилжин ирэх хандлага ажиглагдаж байна.



Харин Ховд аймгийн нийт иргэдийн 11.2%-ийг Казак үндэстэн эзлэж байгаа бөгөөд Монголд улсын нийт Казак үндэстний 10% нь оршин сууж байна. Үүнээс хамааран Ховд аймаг руу жилд дунджаар 100 иргэн Баян-Өлгий аймгаас Ховд аймагт шилжин суурьших магадлалтай байна.

2026 оноос эхлэн Ховд аймаг руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурах төлөвтэй байгаа нь Баян-Өлгий аймгийн эдийн засгийн өсөлттэй холбоотой байна.



Баян-Өлгий аймгаас Улаанбаатар хот болон Ховд аймгаас бусад хот суурин газарт 2010 онд 7000 орчим Казак үндэстэн амьдарч байсан бол 2021 оны байдлаар 10000 орчим Казак үндэстэн амьдарч байна.

Баян-Өлгий аймгаас бусад хот суурин газар руу шилжих хөдөлгөөн нь нийт шилжилтийн 12%-ийг эзэлж байгаа бөгөөд 2018 оноос 2026 он хүртэл өсөх хандлагатай байна. Энэ нь дунджаар 64 иргэн шилжих хөдөлгөөнд оролцоно гэсэн үг.




Үүнээс жилд Дархан-Уул аймаг руу дунджаар 16 хүн, Сэлэнгэ аймаг руу 10 иргэн шилжих төлөвтэй байгаа бол Орхон аймаг руу шилжих хөдөлгөөн 2022-2030 онд дунджаар 9 иргэн байна.




Дээрх аймгууд нь Казак үндэстэн ихээр суурьшсан аймаг бөгөөд Баян-Өлгий аймгаас шилжих хөдөлгөөн нь Казак үндэстний суурьшилтай шууд хамааралтай байна.

Бусад аймагт оршин суугаа нийт Казак үндэстний тоо



Баян-Өлгий аймгийн төрөлт, нас баралт болон шилжилт хөдөлгөөнөөс хамааран Баян-Өлгий аймагт оршин суух хүн амын тоо 2030 онд 121 мянга хүртэл нэмэгдэх боломтжой байна.


БӨА нийт хүн ам



### Шилжин ирэлт

Харин Баян-Өлгий аймгийг зорин ирэх шилжигчдийн хувьд тус аймгийн эдийн засгийн өсөлт буюу нэг хүнд оногдох ДНБ гол нөлөө үзүүлж байна. Шилжин ирэлтийг тооцож үзэхэд нэг хүнд оногдох ДНБ-тэй 71% хамааралтай байгаа нь хүн амын шилжин ирэлтийг нэмэгдүүлэхийн тулд эдийн засгийг төрөлжүүлэх, сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.


Нийт шилжин ирсэн иргэд



	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Нэг хүнд оногдох ДНБ /сая/	1.26	1.68	2.08	2.63	3.22	3.53	3.49	3.56	3.94	4.46
Шилжин ирэлт	<b>22</b>	<b>74</b>	<b>95</b>	<b>233</b>	<b>217</b>	<b>262</b>	<b>270</b>	<b>317</b>	<b>214</b>	<b>154</b>

Бидний бүтээсэн энэхүү системийн динамик загвар дээрээс Баян-Өлгий аймагт шилжин ирэгсдийн тоог, шилжин явагсдын тоог аймгийн хэмжээнд болон сум тус бүрээр ялган харах боломжтой бөгөөд Өлгий, Цэнгэл, Ногооннуур сумд руу чиглэсэн хөдөлгөөн хамгийн их байна.

БӨА бүх шилжин ирэлт




- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Алтай] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Алтай] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Алтанцөгц] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Алтанцөгц] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Баяннуур] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Баяннуур] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Бугар] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Бугар] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Булган] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Булган] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Буюнт] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Буюнт] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Дэлүүн] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Дэлүүн] : Current
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Ногооннуур] : Test
- БӨА бүх шилжин ирэлт[БӨА Ногооннуур] : Current

### Симуляци – Асгатын мөнгөний орд

Асгатын мөнгөний ордыг 2024 оноос ашиглаж эхэлснээр тус аймгийг зорин ирэх шилжих хөдөлгөөн жил бүр дунджаар 30 хүнээр нэмэгдэх боломжтой байна.


### Нийт шилжилт



Нийт шилжилт : Асгатын мөнгөний орд —————  
 Нийт шилжилт : Current —————

Харин шилжин явалт 2026 онд хамгийн өндөр нөлөө үзүүлэх бөгөөд жил бүр дунджаар 270 хүний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах боломжтой болох юм.


### Баян-Өлгий аймгийн шилжин явалт



"Баян-Өлгий аймгийн шилжин явалт" : Test —————  
 "Баян-Өлгий аймгийн шилжин явалт" : Current —————

Ингэснээр Баян-Өлгий аймгийн нийт хүн ам 2030 онд 0.9% нэмэгдүүлэх боломжтой бөгөөд цэвэр шилжилтийн коэффициент 26% нэмэгдэх боломжтой байна. Ингэснээр 2030 онд цэвэр шилжилтийн коэффициент (-3.26) хүрэх юм.

### Цэвэр шилжих хөдлөгөөний коэффициент



Цэвэр шилжих хөдлөгөөний коэффициент : Test —————  
 Цэвэр шилжих хөдлөгөөний коэффициент : Current —————








График 13: Баян-Өлгий аймгийн нийт төрөлт ба Алтанцөгц сумын төрөлтийн хэтийн төлөв



Зураг 3: Нас баралтын сектор




График 14: Баян-Өлгий аймгийн нийт нас баралт ба Өлгий сумын нас баралт хүйсээр, насны ангиллаар

Нас баралтын секторын хамгийн гол хувьсагч бол дундаж наслагт юм.

Дундаж наслагт болон нас баралтанд нөлөөлөх гол хүчин зүйлээр эдийн засгийн нөлөө буюу амьдралын чанарын сайжралтыг авсан. Энэхүү амьдралын чанарын сайжралт гэдэг ойлголтыг төлөөлүүлэн *Дотоодын нийт бүтээгдэхүүн* болон

Долларын ханш хувьсагчуудыг авч үзлээ. Нэг хүнд ноогдох Дотоодын нийт бүтээгдэхүүн нь тодорхой хэмжээгээр нас баралт, дундаж наслалтанд нөлөөлөх бөгөөд 20,000 долларыг давахад түүний нас баралт, дундаж наслалтанд үзүүлэх нөлөө бага болдог байна. Энэ тооцоог 1997 онд Дэлхийн банкнаас гаргасан “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд” баримт дээр үндэслэн боловсруулсан юм.

Наслалтанд нөлөөлж байгаа гол элементээр амьдралын чанарын сайжралтыг авсан бөгөөд загварыг цаашид сайжруулахын тулд дундаж наслалтыг тооцоолохдоо хүнсний тэжээллэг байдал, усан хангамж, агаарын бохирдол зэрэг бусад онцлог нэмэлт элементүүдийг авч үзэж болно.

Дундаж наслалтыг тодорхойлоход маш олон элемент чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд наслалтанд нөлөөлж буй хүчин зүйлүүд улс орон, аймаг орон нутаг болгонд агуулгын хувьд ихээхэн ялгаатай байж болно. Тухайлбал Улаанбаатар хотд нас баралтын гол шалтгаануудын нэг нь агаарын бохирдол болж байна. Энэ нь наслалтыг бууруулахад маш ихээр нөлөөлж байхад хөдөө орон нутагт агаарын бохирдол асуудал биш байхад наслалт бага байгаагийн шалтгаан нь хүнсний тэжээллэг байдал, усан хангамж, эрүүл мэндийн үйлчилгээ, амьдралын хэв маяг, хоол ундны уламжлалт соёл гэх мэт байж болно.

Нас баралтын түвшинг “хэвийн” нөхцөлтэй үеийн нас баралтын үеийн түвшин гэж үзэж болно. Нас баралтын нэмэлт шалтгаан гарвал түүнийг насны-бүлэгт-хамаарах нас баралт үзүүлэлтийг өөрчлөн засварлах, эсвэл өөр секторт тооцоолсон өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг нийт нас баралтад нэмэх замаар загварт оруулж симуляци хийж үзэж болно.




График 15: Баян-Өлгий аймгийн дундаж наслалт

Энэ симуляцид харуулснаар 2030 онд дундаж наслалт 76 орчим байна.

ДУНДАЖ наслалт, улсын дүнгээр 2020 он





График 16: Дундаж наслалт улсын дүнгээр

Баян-Өлгий аймгийн дундаж наслалт Улсын дүнтэй харьцуулахад бусад аймгуудаас өндөр байна.


Хүн амын загварт төрөлт, нас баралт, дотоодын шилжин ирэлт ба явалт, гадаадын шилжин ирэлт ба явалт гэсэн хувьсагч, параметруудийг ашиглан Баян-Өлгий аймгийн 13 сумдын хүн амын ирээдүйн өсөлт, хэтийн төлвийг загварчилсан. Загварчлалд хүн амын шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх гол хүчин зүйлсээр аймаг ба сумдын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, мөн зөөлөн болон хатуу дэд бүтцийн таталцлыг авч үзсэн.

## 2010-2040 оны Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил




**Зураг 4: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил, 2010-2040**

## 2010 оны Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил




Зураг 5: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2010

## 2020 оны Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил




Зураг 6: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2030

## 2030 оны Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил



Зураг 7: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил, 2020

## 2040 оны Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтралшил



**Зураг 8: Баян-Өлгий аймгийн сумдын хүн амын нягтаршил, 2040**



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 48.7 хувь нь 2020 оны байдлаар ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 5.5 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (51.3%) 5.5 пунктээр өсжээ. Ерөнхийд нь үзвэл ажиллах хүчний оролцооны түвшин буурсаар байна. Ялангуяа сүүлийн 2019 ба 2020 онд эрчимтэй буурсан байна.

**Хүснэгт 17: Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, хүйс**

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрэгтэй	81.1	76.7	83.8	75.3	76.3	75.8	73.3	76.3	73.9	45.5	43
Эмэгтэй	74	69.9	79.3	66.8	68.8	68.3	59.2	66.6	66.3	42	34
Бүгд	77.6	73.3	81.5	70.9	72.5	72	66.1	71.5	70	43.7	38.5

**Хүснэгт 18: Баян-Өлгий аймгийн ажиллагчид, аймаг, хүйс**

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрэгтэй	22,208	22,204	23,713	18,069	20,063	23,253	22,022	26,098	26,726	13,989	14,044
Эмэгтэй	19,907	19,801	21,355	16,216	15,892	20,368	17,851	20,480	22,032	11,790	10,810
Бүгд	42,116	42,005	45,068	34,285	35,955	43,621	39,873	46,578	48,758	25,779	24,854



**Зураг 9: Хүн амын эдийн засгийн идэвхийн бүдүүвч зураг /2020 он/**

2021 оны байдлаар Баян-Өлгий аймгийн нийт ажиллагчид 48700, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55,5 болж өмнөх 2020 оноос нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс гадуурах хүн амын тоо 31015 байна.

2022 оны эхний 2 сарын байдлаар Хөдөлмөр дутуу ашиглалтаар авч үзэхэд

-Хөдөлмөрийн насны хүний тоо 78413 /15-65 насны хүн/

-Ажиллах хүчний оролцооны түвшин 60,4%

-Боломжит ажиллах хүч 4600

-Ажилгүйдлийн түвшин 8,2% буюу улсын дундажаас 1,2 нэгж хувиар дээгүүр байна.

-Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 3900

-Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 709, үүнээс

- 52% нь 15-34 насны залуучууд
- 27,3% нь дээд боловсролтой залуучууд байна.

-Нийт ажилгүй иргэдийн тоо 3908 байна.





График 17: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Хүснэгт 19: Ажилд зуучилсан хүний тоо

Утга	2021 он	2022 оны 3 дугаар сарын 19-ны байдлаар
Ажилд зуучилсан хүний тоо	820	113
Үүнээс эмэгтэй	398	17

Хүснэгт 20: Ажил хайгч

Утга	2021 он	2022 оны 3 дугаар сарын 19-ны байдлаар
Ажил хайгч	937	746
Үүнээс эмэгтэй	554	325

Баян-Өлгий аймгийн Өлгийн сумын ажилгүй иргэдийн дунд хийсэн судалгааны үр дүн: /Баян-Өлгий аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар/

Өлгий сумын хэмжээнд хийгдсэн 2021 оны ажилгүй иргэдийн судалгааны үр дүнг авч үзвэл сумын хэмжээнд 5466 иргэн ажилгүй, үүнээс 52% нь эмэгтэйчүүд байна. Гэтэл аймгийн статистик мэдээгээр 8228 ажилгүй иргэн байна гэсэн мэдээ байна.

Ийм мэдээллийн зөрүүтэй байдал орон нутагт маш их байгаа нь бидний хийсэн Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөний тоон мэдээлэл дээрээс харагдаж байна.




График 18 : Ажилгүй иргэдийг хүйсээр харьцуулахад

Өлгий сумын ажилгүй иргэдийг насны бүлгээр авч үзвэл 15-24 насны 298 иргэн, 25-34 насны 2845 иргэн, 35-44 насны 1513 иргэн, 45-54 насны 757 иргэн, 55-59 насны 50 иргэн, 60-аас дээш насны 3 иргэн ажилгүй байна. Ажилгүй иргэдийн 94%-ийг ид ажиллах насны залуучууд бүрдүүлж байгаа нь маш харамсалтай тоо юм.




График 19: Насны бүлгээр харьцуулахад

**Хүснэгт 21: Ажилгүй иргэдийг насны ангилалаар**

Насны ангилал	15-24 нас	25-34 нас	35-44 нас	45-54 нас	55-59 нас	60+ нас
Хүний тоо	298	2845	1513	757	50	3


Ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл 53 хувь нь бүрэн дунд, 21 хувь нь дээд, 14.8 хувь нь бага, 7,6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.6 хувь нь суурь боловсролтой иргэд байна.



**График 20: Боловсролын түвшингээр ангилал**


**Хүснэгт 22: Боловсролын түвшингээр**

Боловсролын түвшин	Бага боловсролтой	Суурь боловсролтой	Бүрэн дунд боловсролтой	Тусгай мэргэжлийн дунд боловсролтой	Дээд боловсролтой
Хүний тоо	811	168	2923	419	1145



**График 21: Боловсролын түвшингээр харьцуулсан байдал**


Ажилгүйчүүдийн хөдөлмөрийн чадварын байдлаар авч үзвэл 8.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.




**График 22: Хөдөлмөр чадварын байдал**

2020 оны байдлаар гадаадад тоологдсон хүн амын дүн буюу 122301 хүний 5250 нь Баян-Өлгий аймагт тоологдож улсын гадаадад тоологдсон хүний 4.3 хувийг эзэлж байна. 21 аймаг дотор гадаадад тоологдсон хүн амын хувиар хамгийн их нь Улаанбаатар хот дараа нь Баян-Өлгий, Дархан-Уул, Орхон аймаг орж байна. Гадаадад тоологдсон иргэдийн 94.9 хувь нь Казакстан улсад, 1.6 хувь нь Турк улсад сууж байна.

Гадаадад оршин суугаа хүмүүсийн 22.3 хувь нь суралцах, 38.2 хувь нь суурьших, 2.9 нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 10.9 хувь нь хувиараа ажиллах, 16.6 хувь гэр бүлийн шалтгаанаар, 9 хувь нь бусад шалтгаантай байна.



**График 21: Баян-Өлгий аймгийн нийт ажил эрхлэлт ба ажилгүйдлийн түвшин**



Ажилгүй иргэд[БӨА Өлгий] : current

Ажиллах хүчнээс гадуурх иргэд[БӨА Ногоонуур] : current

График 22: Өлгий сумын ажилгүй иргэд ба Ногооннуур сумын ажиллах хүчнээс гадуурх иргэдийн тоо

### НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 онд Баян-Өлгий аймагт нийгмийн халамжийн үйлчилгээнд 54077 иргэнийг хамруулсан бөгөөд улсын төсвөөс 22.8 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс 166 сая төгрөг тус тус зарцуулсан.

Баян-Өлгийн аймгийн хүн ам харьцангуй залуучууд, хүүхдүүд ихтэй учир Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг аймгийн хэмжээнд 44850 хүүхэд, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 1858 өрхийн 5555 том хүн, 5065 хүүхэд хамрагдаж байгаагийн 3710 нь хөдөлмөр эрхлэх чадвартай иргэн байна.

Нийгмийн халамжийн сангаас олгодог халамжийн тэтгэвэр, тэтгэмж, Алдарт эхийн одон, насны хишгийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоон судалгааг авч үзье. /2016.04.01-2021.12.31-ний өдрийн байдлаар/

Хүснэгт 23: Алдарт эхийн одон, Насны хишиг

№	Сумын нэр	Үйлчилгээний төрөл бүлгээр											
		Алдарт эхийн одон						Насны хишиг					
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Алтай	42	428	442	453	437	475	0	127	139	142	144	156
2	Алтанцөгц	26	316	339	340	343	380	0	102	101	105	106	128
3	Баяннуур	87	566	612	602	577	580	0	165	170	151	153	168
4	Бугат	36	391	406	395	397	430	0	122	131	135	142	159
5	Булган	40	595	631	634	620	620	0	160	186	178	183	205
6	Буянт	28	272	293	295	285	290	0	82	84	87	89	95
7	Дэлүүн	57	838	868	887	850	950	0	203	246	248	254	269
8	Ногооннуур	106	687	726	711	687	695	0	174	201	210	220	228
9	Өлгий	256	3269	3300	3,300	3140	3640	0	1008	1118	1,191	1210	1289
10	Сагсай	60	612	654	647	621	648	0	192	194	202	206	214
11	Толбо	71	480	542	507	495	520	0	146	176	164	160	186
12	Улаанхус	125	938	1037	1,016	950	992	0	240	280	270	272	284
13	Цэнгэл	136	981	1040	1,043	935	998	0	232	263	256	260	281
14	Цагааннуур	15	110	128	123	113	108	0	43	43	48	50	52
<b>Нийт дүн</b>		<b>1085</b>	<b>10483</b>	<b>11018</b>	<b>10,953</b>	<b>10450</b>	<b>11326</b>	<b>0</b>	<b>2996</b>	<b>3332</b>	<b>3,387</b>	<b>3449</b>	<b>3714</b>

Хүснэгт 24: Халамжийн тэтгэвэр, Асаргааны тэтгэмж, Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж

№	Сумын нэр	Үйлчилгээний төрөл бүлгээр																	
		Халамжийн тэтгэвэр						Асаргааны тэтгэмж						Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж					
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Алтай	110	131	129	358	141	200	86	86	101	389	160	154	87	93	107	179	72	99
2	Алтанцөгц	65	67	60	96	74	180	55	41	42	279	96	95	62	48	54	130	75	69
3	Баяннуур	93	109	106	258	148	120	87	75	92	310	125	115	95	83	104	198	90	88
4	Бугат	110	127	128	236	189	90	63	46	57	320	114	90	72	55	60	190	80	80
5	Булган	153	202	200	384	225	120	89	92	97	325	146	136	97	101	103	198	92	100
6	Буянт	61	74	78	106	84	50	41	38	37	150	81	80	47	41	42	100	59	64
7	Дэлүүн	164	188	193	388	276	150	151	112	124	394	142	125	163	128	132	206	111	108
8	Ногооннуур	139	166	157	348	241	130	89	59	65	320	126	120	101	66	68	202	81	78
9	Өлгий	989	1201	1139	1,986	14	900	431	486	454	700	280	276	457	507	523	368	290	280
10	Сагсай	93	115	119	312	1112	120	51	54	74	300	120	109	61	63	79	186	86	84
11	Толбо	137	170	178	294	198	150	63	57	69	194	85	76	71	65	73	169	68	88
12	Улаанхус	181	244	253	348	183	190	114	109	123	210	71	70	124	126	138	240	80	90
13	Цэнгэл	185	221	242	452	264	160	74	81	98	202	103	102	85	92	105	202	94	80
14	Цагааннуур	21	23	22	45	38	23	16	19	21	40	20	22	18	21	23	28	20	35
<b>Нийт дүн</b>		<b>2501</b>	<b>3038</b>	<b>3004</b>	<b>5,611</b>	<b>3187</b>	<b>2583</b>	<b>1410</b>	<b>1355</b>	<b>1454</b>	<b>4,133</b>	<b>1669</b>	<b>1570</b>	<b>1540</b>	<b>1489</b>	<b>1611</b>	<b>2596</b>	<b>1298</b>	<b>1343</b>

Хүснэгт 25: Жирэмсэн эхийн тэтгэмж, Цалинтай ээж хөтөлбөр, Өрх толгойлсон

№	Сумын нэр	Үйлчилгээний төрөл бүлгээр																	
		Жирэмсэн эхийн тэтгэмж						Цалинтай ээж хөтөлбөр						Өрх толгойлсон					
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Алтай	125	114	52	56	53	48	0	0	226	259	289	274	1	1	8	9	8	9
2	Алтанцөгц	77	86	32	35	32	38	0	0	144	182	175	150	0	0	3	4	5	7
3	Баяннуур	123	140	50	60	58	52	0	0	202	204	199	225	5	4	16	12	9	13
4	Бугат	110	115	36	55	22	36	0	0	211	250	248	239	0	0	4	7	8	7
5	Булган	145	149	52	67	48	60	0	0	265	280	260	290	0	0	7	8	10	12
6	Буянт	82	72	28	78	37	42	0	0	149	162	140	136	2	0	4	9	8	8
7	Дэлүүн	205	198	74	80	76	81	0	0	384	396	384	371	0	0	8	9	11	10
8	Ногооннуур	180	186	60	102	58	65	0	0	289	328	315	362	3	4	13	11	8	9
9	Өлгий	980	1011	343	420	260	278	0	0	1785	1,889	1876	1952	11	12	55	47	38	50
10	Сагсай	162	181	54	98	75	70	0	0	302	359	341	328	0	0	12	13	14	10
11	Толбо	117	122	34	105	90	82	0	0	213	285	282	246	1	2	7	11	8	4
12	Улаанхус	223	248	73	202	95	102	0	0	434	468	462	413	0	0	10	11	7	9
13	Цэнгэл	282	296	103	282	103	95	0	0	516	540	528	499	11	0	18	15	9	11
14	Цагааннуур	44	50	12	42	19	15	0	0	76	82	69	68	0	0	4	3	6	5
<b>Нийт дүн</b>		<b>2855</b>	<b>2968</b>	<b>1003</b>	<b>1,682</b>	<b>1026</b>	<b>1064</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>5196</b>	<b>5,684</b>	<b>5568</b>	<b>5553</b>	<b>34</b>	<b>23</b>	<b>169</b>	<b>169</b>	<b>149</b>	<b>164</b>






График 23: Баян-Өлгий аймгийн нийт тэтгэвэрт гарсан хүн ам ба халамжийн тэтгэвэр авагчдын тоо





График 24: Баян-Өлгий аймгийн 0-18 насны хүүхдийн мөнгө авдаг иргэд ба алдарт эхийн одонтой эхчүүд

**Хүснэгт 26: Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгаа**


№	Хөтөлбөрийн нэр	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	Хамрагдсан хүний тоо	Бий болсон ажлын байрны тоо
1	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	1875,0	3199	2543
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	389,4	475	151
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	372,2	656	90
4	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	906,9	716	322
5	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	128,3	1313	389
6	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	183,7	221	214
7	Жижиг зээл	2167,7	373	400
8	Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл	200,0	9	26
9	Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх оролцоо төсөл		109	45
10	Хүүхэд хамгаалагч төсөл	7,4	9	9
	<b>Дүн</b>	<b>6230,6</b>	<b>7080</b>	<b>4189</b>

Дээрх судалгаанаас харвал **Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл, Жижиг зээлийн** санхүүжилтийг нэмэгдүүлэх нь илүү үр дүнтэй байхаар харагдаж байна.




**График 25: Баян-Өлгий аймгийн ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлэх үеийн ажилтай болох иргэдийн тоо**

Нийт халамж авдаг иргэдийн тоог /хүүхдийн мөнгө ороогүй/ бүх иргэдийн тоонд харьцуулан харвал




Энд бид тооцоо хийж үзэхэд тус аймгийн Халамж авдаг иргэдийн тоо 2 төрөл дээр улсын дундажаас их байна.

1. Одонтой ээжүүдийн тоо улсын дундажаас 40 орчим хувиар илүү бөгөөд яг адил хүн амтай Дархан-Уул аймгаас 35 хувиар илүү байна.



2. Тэжээгчээ алдсаны тэтгэмж




Баян-Өлгий аймагт 2021 оны байдлаар нийт 1506 хүн тэжээгчээ алдасны тэтгэвэр авч байна.

Эдгээр тоог харьцуулан үзвэл.

- Тэжээгчээ алдасны тэтгэвэр авагчид болон тухайн онд нас барсан хүмүүсийн тоог харьцуулан үзэхэд 2010 оноос хойш дундаж харьцаа 4.1 байна. Харин Дархан-Уул аймгийн дундаж 1.2 байна.
- Харин 1992 оноос хойших нас баралтыг өссөн дүнгээр тооцож тухайн оны тэжээгчээ алдасны тэтгэмж авдаг тоонд харьцуулахад дундаж харьцаа 0.15 байна. Энэ нь Дархан-Уул аймгийн харьцаанаас 2.8 дахин өндөр байна.

### Цэцэрлэгийн сектор



**Зураг 10: Цэцэрлэгийн сектор**

Энэ сектороос бид цэцэрлэгт хамрагдсан нийт хүүхдүүдийн тоо болон цэцэрлэгийн бүлгийн нийт тоо, багш ажилчдын тоог харна. Цэцэрлэгийн хүүхдүүдийн тоог нэгээс дөрвөн анги болгон задалж, хүйс тус бүрээр нарийвчлан харах боломжтой. Эдгээр мэдээллийг ашиглан аймгийн хэмжээнд, сумын хэмжээнд цэцэрлэгийн барилга байгууламж, анги танхим, багш ажилчдын хүрэлцээ зэргийг урьдчилан төлөвлөж, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг зохицуулах боломжтой юм.

### Нийт цэцэрлэгт хамрагдагчид сум сумаар





График 23: Нийт цэцэрлэгт хамрагдагсад сум сумаар

### Бага боловсролын сектор



Зураг 11: Бага боловсролын сектор

Бага боловсролын сектор нь хүүхдийн бага сургуульд хамрагдаж, бичиг үсэгт тайлагдсан хүн амын хэсэг болж өсөн хөгжиж байгааг харуулна. Энэ сектороос бага ангид суралцдаг нийт хүүхдүүдийн тоо болон багшийн тоон мэдээллийг харна. Бага ангийн хүүхдүүдийн тоог нэгээс тавдугаар анги болгон задалж, хүйс тус бүрээр нарийвчлан харах боломжтой.


Эдгээр мэдээллийг ашиглан аймаг, сумдын хаана нь, хэдэн онд сургуулийн барилга байгууламж барих, анги танхим, багш ажилчдын хүрэлцээ ямар болох зэргийг урьдчилан төлөвлөж, шаардлагатай онуудад хэрэгцээт хөрөнгө оруулалтын хэмжээг аймгийн төсөвт суулгаад явах боломжтой юм.



хүйстэй холбоотой боловсролын асуудлыг авч үзэж болно. Өөрөөр хэлбэл Баян-Өлгий аймгийн хувьд бүрэн дунд боловсрол эзэмшиж байгаа сурагчдын хэдэн хувь нь охид, хэдэн хувь нь хөвгүүд байгааг эндээс харж болно.

Эдгээр мэдээллийг ашиглан аймгийн хэмжээнд сургуулийн барилга байгууламж, анги танхим, багш ажилчдын хүрэлцээ зэргийг урьдчилан төлөвлөж, шаардлагатай онуудад, хэрэгцээт хөрөнгө оруулалтын хэмжээг аймгийн төсөвт суулгаад явах боломжтой юм.

Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн дунд ангид элсэгчдийн тоон динамикийг харвал:




**График 25: Дунд ангид элсэгчид**

Баян-Өлгий аймгийн бүрэн дунд боловсролын сурагчдын тоо:



авч үзсэн. Нэг эмчид оногдох дундаж хүн амын тоо параметрийг өөрчлөх замаар симуляци хийж өвчлөлийн эдгэлтийг ихэсгэж бууруулах боломжтой.



**График 27: Нийт халдварт өвчнөөр өвчилсөн хүн ам**

Жилд дундажаар 2500-3000 иргэн Улаанбаатар хотод ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авдаг байна. Энэ тоог Баян-Өлгий аймагт бүсийн оношилгооны төв буюу 3-р шатны эмнэлэг барих замаар бууруулж болно.



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Баян-Өлгий аймгийн Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь байгаль, цаг агаараас хэт хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ аймгийн хүн амын хүнсний хэрэглээ, зарим боловсруулах үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагддаг.

Баян-Өлгий аймгийн хувьд хөдөө аж ахуйн салбар нь голлох эдийн засгийн салбаруудын нэг билээ. Баян-Өлгий аймгийн ДНБ-ний 35%-өөс дээш хувийг ХАА салбар дангаараа бүрдүүлж ирсэн байна.



График 28: ХАА-н үйлдвэрлэл, тэрбумаар



График 29: ХАА-н үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь

2010 онд нэг хүнд ХАА-н үйлдвэрлэл 535077 төгрөг оногдож байсан бол 2020 онд 1956150 төгрөг болж 3,7 дахин өссөн байна.

2010 онд нэг хүнд ДНБ 1.27 сая төгрөг оногдож байсан бол 2020 онд 4.2 сая төгрөг болж 3.33 дахин өссөн байна.




График 30: ХАА-н үйлдвэрлэл ба нэг хүнд ногдох ДНБ



График 31: ХАА-н үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь

Баян-Өлгий аймгийн Хөдөө аж ахуйн салбар 2010 оноос 2020 он хүртэл 4.8 дахин өссөн ба энэ нь Говь-Алтай аймгаас 3 дахин бага, Ховд аймгаас 0.7 дахин илүү өсөлт үзүүлсэн байна.



График 32: ХАА-н үйлдвэрлэл өсөлт Баруун 5 аймагт

Нийт малын тоо болон таван төрөл 2010-2021 онуудад хэрхэн өсөн нэмэгдэж байгааг дараах динамикаас харах боломжтой.



График 33: Баян-Өлгий аймгийн нийт малын тоо толгой




График 34: Баян-Өлгий аймгийн нийт бод малын тоо толгой




График 35: Баян-Өлгий аймгийн нийт бог малын тоо толгой

Мал сүргийн тоо толгой дээрээс мал аж ахуйн үйлдвэрлэлийг гарган авна.




График 36: Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэл

Баян-Өлгий ХАА-н үйлдвэрлэлд МАА-н үйлдвэрлэл бараг дангаараа 92 -өөс дээш хувийг эзэлж байна.



График 37: Мал аж ахуйн үйлдвэрлэл ХАА-н үйлдвэрлэлд эзлэх хувь

Баян-Өлгий аймгийн хувьд Газар тариалан сайн хөгжөөгүй сул талтай бөгөөд хувийн хэрэгцээндээ тарьж ашиглаж байна.



График 38: Баян-Өлгий аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл



График 39: Газар тариалангийн үйлдвэрлэл ХАА үйлдвэрлэлд эзлэх хувь

Баруун 5 аймгийн газар тариалангийн салбарын ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл Ховд хамгийн өндөр 3.1% эзэлсэн бол Говь-Алтай аймаг 0.6% эзэлж байна. Баян-Өлгий аймгийн хувьд газар тариалангын салбар нь ДНБ-ий 2.5% эзэлж байна.





График 40: Газар тариалангийн үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН СИСТЕМЫН ДИНАМИК ЗАГВАР

## Мал аж ахуй

Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн салбарын загварт байгалийн гамшиг, бэлчээрийн даац, бүс бүслүүр (говь,хээр,хангай), нэг малын бэлчээрлэх газрын хэмжээ зэрэг нь гол хүчин зүйл болж өгсөн.



Зураг 14: Баян-Өлгий аймгийн мал аж ахуйн загвар

## Нийт малын тоо





График 41: Баян-Өлгий аймгийн нийт малын тоо толгойн хэтийн төлөв

Аймгийн бэлчээрийн малын тоог 5-н хошуу мал бүрээр, сум тус бүрээр гаргах боломжтой. Мөн бэлчээрийн даац, байгалийн гамшиг, малын хөлийн татвар, эрчимжсэн болон хагас эрчимжүүлэх туршилт, симуляцийг оруулж өгсөн. Загварт бэлчээрлэх газар нутгийн хэмжээний хувь параметр-ийг хөдөлгөн малын тооны өсөлтийг өөрчлөн харах боломжтой. Баян-Өлгий аймаг өндөр уулын бүсэд оршдог бэлчээрийн хүрэлцээ бага тул энэ тоог багасгах боломжтой бөгөөд малын тооны өсөлт үүнийг дагаад буурах болно.


### Малын тоо төрлөөр



**График 42: Баян-Өлгий аймгийн малын тоо таван төрлөөр**

2019 оны байдлаар хамгийн их малтай нь Цэнгэл сум бөгөөд сүүлийн 10 жилийн малын өсөлт, газар нутгийн хэмжээ, ган зуд болоогүй зэрэг хүчин зүйлийг өөдрөгөөр төсөөлвөл малын тоо толгойн динамик дараах байдлаар өсөхөөр байна.


### БӨА Бэлчээрийн малын тоо толгой



**График 43: Цэнгэл сумын малын тоо толгойн хэтийн төлөв**

Аймгийн нийт мал сүргийн динамикийг харахаас гадна сум болон малын төрөл тус бүрээр динамикуудыг харах боломжтой. Энэ үед ган зуд болоогүй хэвийн байхаар тооцсон бөгөөд зөвхөн бэлчээрийн даацыг гол хүчин зүйл болгосон.


Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах туршилт симуляцийг бид загвартаа оруулж өгсөн. Тухайлбал мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах, малыг үйлдвэрийн аргаар нядлах, мах, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, малын арьс, ширийг хагас болон бүрэн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ноос, хөөвөр, ноолуурыг угаах, самнах, ээрэх үйлдвэрүүдийг орон нутагт барих, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэх мэт симуляциудыг хийж болох бөгөөд эдгээрийг бүрэн хийж чадвал аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэл 2.5 их наяд төгрөг буюу 3,4 дахин нэмэгдэх боломжтой. Энэ үед нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 24,79 сая төгрөг буюу 2,2 дахин нэмэгдэнэ.



**График 44: Баян-Өлгий аймгийн малын гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулах симуляцийн дараах мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл ба аймгийн 1 хүнд ноогдох ДНБ**


**Газар тариалан**

Газар тариалангийн загварын харагдах ерөнхий байдлыг дараах зурагт харуулсан. Энэ загварт тариалангийн талбайг усалгаатай болгох, механикжуулах, байгалийн гамшиг тохиолдох, мал аж ахуйн нөлөө зэрэг гол хүчин зүйлүүдийг тооцсон.



**Зураг 15: Баян-Өлгий аймгийн газар тариалангийн загвар**

Газар тариалангийн салбарын гаргаж буй бүтээгдэхүүнийг Тариа, Төмс, Тэжээлийн ургамал, Техникийн ургамал, Хүнсний ногоо, Жимс жимсгэнэ гэсэн 6 төрлөөр сум тус бүрд авч үзсэн.




**График 45: Баян-Өлгий аймгийн Газар тариалангийн салбарын үйлдвэрлэл ба Бугат, Булган сумын төмсний ургацын хэмжээ**




Аймгийн хэмжээгээр одоогийн байдлаар газар тариалангаас 18 тэрбум хүртэлх төгрөгний орлого олдог. Тариалангийн газраа нэмэгдүүлэх, эко бордооны хэрэглээг нэмэгдүүлэх, механикжуулах, усалгаатай талбайн хэмжээг ихэсгэх, хүлэмжийн аж ахуй эрхлэх зэрэг туршилтыг хийж болно.

Жишээ болгон Булган суманд хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлж үзвэл жимс, жимсгэнийн ургац нэмэгдэх бөгөөд үүнийг дагаад усны хэрэглээ нэмэгдэхээр байна.




**График 43: Булган сумын жимс жимсгэнийн ургац ба усны хэрэглээ**



**График 46: Баян-Өлгий аймгийн ХАА-н бусад салбараас олох орлого хэтийн төлөв**

Баян-Өлгий аймгийн нийт ХАА-н үйлдвэрлэлийн загварын үр дүн, түүхэн үйлдвэрлэлийг доор харьцуулсан болно.

Баян-Өлгий аймгийн МАА, газар тариалан болон ХАА-н бусад салбарын нийт үйлдвэрлэлийг тооцолон үзэхэд 2030 он гэхэд 764 тэрбум төгрөгт хүрэх боломжтой байна. Энэ нь Баян-Өлгий аймгийн ХАА-н салбар ДНБ-ны 45%-ийг бүрдүүлэх төлөвтэй байна.



**График 47: Баян-Өлгий аймгийн ХАА-н орлого хэтийн төлөв**

Түүнчлэн Баян-Өлгий аймгийн ХАА салбарын ажил эрхлэлт 25 мянга хүрэх боломжтой байна.



"Нийт ХАА-н ажил эрхлэлт": Test


**График 48: Нийт ХАА-н ажил эрхлэлт**

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЕРӨХНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Баян-Өлгий аймгийн хувьд 2020 оны байдлаар 185 тэрбум төгрөгийн орлогыг худалдаа, үйлчилгээний салбараас олсон ба энэ нь Баян-Өлгий аймгийн ДНБ-ний 39 хувийн бүрдүүлж байна. Худалдаа, үйлчилгээний салбар нь мөн хөдөлмөрийн зах зээлийн нэн чухал салбар бөгөөд аймгийн хэмжээнд 12830 хүн ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд Монгол улсын гадаад хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засаг илүү гадаад зах зээл рүү чиглэх болсноор түүнийг дагасан ажил хэрэг болон аяллын зорилгоор аялал жуулчлалын салбар ихээхэн хөгжиж байна. Баян-Өлгий аймгийн үзэсгэлэнт байгальд аялахаар дотоодын болон гадаадын аялагчид олноор ирэх болсон. Мөн Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбогдох болсон дотоодын аялал жуулчлалыг ихээр нэмэгдүүлэх болно. Энэ нь ялангуяа худалдаа, үйлчилгээний салбарт маш таатай хандлага болох нь тодорхой юм.


Баян-Өлгий аймгийн ДНБ-ний голлох салбар бол худалдаа, үйлчилгээний салбар бөгөөд энэ нь доорх графикаас харахад тодорхой байна. Үйлчилгээний салбар нь жил бүр дунджаар 5-10 хувиар тогтмол өсөж байна. Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага мөн дагаж өсөн нэмэгдэж байна.

2010 онд нэг хүнд Үйлчилгээний үйлвэрлэлийн 585187.6212 төгрөг ногдож байсан бол 2020 онд 1667727 төгрөг болон 2.7 дахин өссөн байна.



**График 49: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэл ба ДНБ**

2010-2020 оны дунджаар Худалдаа, Үйлчилгээний үйлдвэрлэл дангаараа **32%** ийг эзэлж байна.



**График 50: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэл ДНБ-д эзлэх хувь**

Баян-Өлгий аймгийн нийт ажил эрхлэлтийн ихээхэн хувийг үйлчилгээний салбарын ажил эрхлэлт эзэлж байна. 2018 оны байдлаар Баян-Өлгий аймагт 48758 хүн ажил эрхэлж байгаа бөгөөд үүнээс 15546 хүн нь Үйлчилгээний салбарт ажиллаж байна. Өөрөөр хэлбэл 31 хувь нь энэ салбар ажиллаж байгааг харуулж байна.

Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын ажилчдын тоог дараах хүснэгтээс харахад сүүлийн жилүүдэд тогтмол бус байдаг нь харагдаж байна.




График 51: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын ажиллагсад

2020 оны байдлаар Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 39.4%-д хүрсэн бөгөөд баруун 5 аймгийн Үйлчилгээний салбарын хамгийн өндөр хувийг эзэлж байна. Энэ нь Баян-Өлгий аймгийн байгалийн онцлог, хилийн боомт, аялал жуулчлалын таталцал зэргээс хамаарсан бөгөөд цаашид ч хөгжих боломжтой байна.






График 52: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь





**График 53: Баян-Өлгий аймгийн үйлчилгээний үйлдвэрлэлийн хэтийн төлөв**

Баян-Өлгий аймгийн хувьд Үйлчилгээний салбарын өсөлтийг даган ажиллах хүчний тоо өсч байна.



**График 54: Баян-Өлгий аймгийн Үйлчилгээний салбарын ажиллах хүчний төлөв**

Тус секторт шинээр хөрөнгө оруулалт хийвэл салбарын үйлдвэрлэл хэрхэн нэмэгдэх, хэдэн ажлын байр шинээр үүсэх, улмаар аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны гол үзүүлэлтүүдийн алинд нь эерэг бөгөөд сөрөг нөлөө үзүүлэхийг харах, тооцоолох боломжийг олгоно.

### **БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ОДООГИЙН БАЙДАЛ**

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын томоохон хэсгийг бүрдүүлэгч Баян-Өлгий аймаг нь 2019 онд 8019 гадаадын жуулчид хүлээн авсан бөгөөд 2020 оноос цар тахлын улмаас Гадаадын жуулчид хумигдаж дотоод аялал жуулчлал эрчимжсэн байна. Мөн Баян-Өлгий аймаг нь Улаанбаатар хот-той хатуу хучилттай автозамаар холбогдсон нь дотоод аялал жуулчлалын дэлгэрүүлэхэд томоохон нөлөө үзүүлсэн байна. 2020 онд Баян-Өлгий аймаг нь 22 мянган дотоодын аялагчид хүлээн авсан байна.




График 55: Баян-Өлгий аймагт ирсэн жуулчид

Цаашид гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд 2030 онд гэхэд 43 мянга гаруй дотоод, гадаадын аялагчид Баян-Өлгий аймгийг зорино.





График 56: Баян-Өлгий аймгийн жуулчдын хэтийн төлөв

Тус аймгийн үндэсний өв соёл болсон бүргэдийн баяр нь Аялал жуулчлалын салбартаа томоохон нөлөө үзүүлэгч бөгөөд Бүргэдийн баяраар дамжуулан бүргэдээр ан хийх зан үйлийг дэлхий дахинд сурталчилан таниулсаны дүнд ЮНЕСКО-ийн Дэлхийн биет бус өвийн хорооны 2010 оны 11 сард болсон хуралдаанаар Дэлхийн биет бус соёлын өвийн жагсаалтад бүртгэсэн байдаг. Бүргэдийн баяр нь эдүгээ Монгол улсын аялал жуулчлалын эвентүүдийн хамгийн сонирхолтой баярын нэг болсон байна.

Бүргэдийн баяраар 2019 онд 1500 гаруй аялагч Баян-Өлгий аймгийн зорьсон бол энэ тоо цаашид нэмэгдэн 2030 онд 4000 аялагчид хүрэх төлөвтэй байна.




**График 57: Бүргэдийн баярт ирэх жуулчид**

Аялал жуулчлалын салбарын энэ хүү өсөлтөөр Баян-Өлгийн аймгийн аялал жуулчлалын салбар 2030 онд 30 тэрбум төгрөг олох боломжтой байгаа бөгөөд аялагчдын тоог цаашид нэмэгдүүлэхийн тулд Аялал жуулчлалын салбарын хөрөнгийг байнга нэмэгдүүлэх шаардлагатай байна.



**График 58: Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын салбарын орлого**

Мөн Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын салбарт нөлөө бага үзүүлсэн дотоод, хувийн аялал зохион байгуулсан майхантай аялагчидын тоо 2026 он хүртэл нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд 2026 оноос аялал жуулчлалын салбарын хөгжил, хүртээмж зэргээс шатгаалан энэ тоо буурах хандлагатай байна.




**График 59: Майхантай аялагчдын тоо** **График 60: Майхантай аялагчид**



Эдгээр аялагчдаас нийт 1 тэрбум гаруй төгрөгний нэмэлт орлого олох боломжтой байсан бол 2026 онд хамгийн дээд хэмжээ буюу 1.4 тэрбум хүртэлх төгрөгийн алдагдсан боломж байна.

аас шалтгаалан Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын салбарт а:



"Майхантай аялаас шалтгаалан Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын салбарт алдагдсан боломж": Test

**График 61 : Майхантай аялагчид**

Дотоодын эдгээр аялагчид аялах хугацаандаа түр хогийн цэгт 190-280 тонн хог хаягдал ялгаруулах ба дээрх хог хаягдалыг ойр байгаа сумдын хогын үндсэн цэгт зөөвөрлөх шаардлага тулгарч байна. Иймд хариуцлагатай аялал жуулчлалыг нэмэгдүүлэх, дэмжих шаардлага хаа хаана тулгарч байна.

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ОДООГИЙН БАЙДАЛ

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт нь дамжуулан борлуулсан цахилгааныг оролцуулаад 2018 онд 29294.3 сая төгрөг болсон нь үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 28.7 хувиар, борлуулалтын хэмжээ 14.8 хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 27: Аймгийн ДНБ болон Аж Үйлдвэрийн салбар**

**АЙМГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН /хэмжих нэгж сая.төг/**

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Дотоодын нийт бүтээгдэхүүн /он/					
	2016	2017	2018	2019	2020	
ДНБ-Бүгд, зах зээлийн үнээр	307,060.0	326,833.6	370,892.5	407,170.5	469736	
Хөдөө аж ахуй	119,497.3	115,235.2	142,716.0	179,696	217,004	
Үйлдвэрлэл	45,816.77	47,367.27	57,286.277	64,910.8	67,725.5	
Үйлчилгээ	138,137.1	152,854.0	159,558.7	180,976.8	185007.57	
<b>АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ</b>						
Салбар	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Уул уурхай, олборлолт	7979.4	7433.3	7722.4	10712.7	8874.6	82.8
Боловсруулах үйлдвэр	25156.6	28275.0	36658.5	44680.6	54465.7	121.9
Цахилгаан, дулаан, усан хангамж	5409.3	5486.4	5999.5	7253.8	8321.9	114.7

*/Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн статистикийн эмхэтгэл 2020/*

2020 оны байдлаар Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 67 тэрбум төгрөгт хүрэх 2010 оноос 5.7 дахин өссөн өндөр үзүүлэлттэй байна.



**График 62: Баян-Өлгий аймгийн нийт үйлдвэрлэл /Сая төгрөг/**

Баруун бүсийн аж үйлдвэрийн салбарт 2010 оноос хойш Говь-Алтай аймгийн үйлдвэрлэл 51.9 дахин өсөж хамгийн өндөр өсөлт үзүүлэн 78.7 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бол Увс аймаг хамгийн бага буюу 4.2 дахин нэмэгдэж

үйлдвэрлэлийн хэмжээ 72 тэрбум төгрөг байна.Ховд аймгийн үйлдвэрлэл 181.1 тэрбум төгрөг хүртэл нэмэгдэж 2010 оноос 10.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Баян-Өлгий аймгийн хувьд Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл бусад аймгаас хамгийн бага буюу 67.7 тэрбум төгрөг байгаа нь энэ салбарыг цаашид анхааран хөгжүүлэх шаардлагтай гэдэг нь харагдаж байна.



График 63: Баруун 5 аймгийн аж үйлдвэрийн салбарын өсөлт 2010 оноос 2020 он хүртэл

Мөн Баян-Өлгий аймгийн Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь бүс нутагтаа хамгийн бага буюу 14.4% байна. Ховд аймаг хамгийн өндөр үйлдвэрлэлтэй аймаг бөгөөд ДНБ-н 31.3%-ийг эзэлж байна.





График 64: Баруун 5 аймгийн аж үйлдвэрийн салбарын ДНБ-д эзлэх хувь 2020 он

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗАГВАР



Зураг 17: Аж үйлдвэрлэлийн салбарын систем динамик загвар

## Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн салбарын хэтийн төлөв

Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрийн салбарын өсөлт цааш үргэлжлэх хандлагатай байгаа бөгөөд энэхүү өсөлт нь 2030 онд 185.6 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл




График 65: Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн хэтийн төлөв




График 66: Баян-Өлгий аймгийн аж үйлдвэрлэлийн хэтийн төлөв, сумдаар

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАРИЛГЫН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

Баян-Өлгий аймгийн барилгын салбарын үйлдвэрлэл 2010 онд 176 сая төгрөг байсан бол 2020 онд 833.4 сая төгрөгт хүрэн 4.7 дахин нэмэгдсэн байна.



График 67: Баян-Өлгий аймгийн барилгын үйлдвэрлэл /сая.төгрөг/

Барилгын салбарын өсөлт нь Баруун бүсэд Ховд, Увс аймгийн ард ард эрэмблэгдсэн бөгөөд Завхан болон Говь-Алтай аймгаас өндөр байна.




График 68: Баруун бүсийн барилгын салбарын өсөлт /сая.төгрөг/

Барилгын салбарын үйлдвэрлэл нь нийт ДНБ-н 1.7%-ийг эзэлж байна. Баруун бүсийн хамгийн өндөр хувь эзэлж байгаа аймаг Ховд аймаг бөгөөд барилгын салбар нь ДНБ-н 5.8% -ийг эзлэж байна.



График 69: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын ДНБ-д эзлэх хувь

## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАРИЛГЫН САЛБАРЫН ХЭТИЙН ТӨЛӨВ

Аймгийн барилгын салбар нь цаашид өсөх хандлагатай бөгөөд 2030 он гэхэд 32.87 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.



График 70: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын хэтийн төлөв

Баян-Өлгий аймгийн барилгын салбарыг сумдаар ангилан харвал дийлэнх хувийг Өлгий сум эзлэж байна. Бусад суманд энэхүү салбарын өсөлт маш бага харагдаж байгаа ба цаашид сумдын барилгын салбарыг хөгжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай байна.





График 71: Баян-Өлгий аймгийн барилгын салбар сумдаар

Баян-Өлгий аймгийн статистик тоон мэдээнд 2010 онд барилгын салбарын ажил эрхлэлт 365 байсан бол загварын тооцооллоор 2030 он гэхэд 2415-д хүрэх боломжтойг болохыг тооцоолсон байна.




График 72: Баян-Өлгий аймгийн барилгын салбарын ажил эрхлэлтийн хэтийн төлөв

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХЭТИЙН ТӨЛӨВ




Аймгийн уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2014-2020 онуудад өсөлт багатай байсан боловч 2023 оноос өсч эхлэх бөгөөд 2030 он гэхэд 9 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Энэ үр дүнд Асгатын мөнгөний үйлдвэрлэлийг тооцоогүй бөгөөд Асгатын мөнгөний ордны нөлөөг туршилт симуляци хийх байдлаар загварт оруулсан.

Уул уурхайн нийт үйлдвэрлэл




Асгатын мөнгөний ордыг 2025 оноос ашиглаж эхлэнэ гэж үзвэл аймгийн ДНБ 7.1%, ажил эрхлэлт 6.1% нэмэгдэж ажилгүйдлийн түвшин буурах боломжтой байна.

Уул уурхайн нийт үйлдвэрлэл



Уул уурхайн нийт үйлдвэрлэл : test  
Уул уурхайн нийт үйлдвэрлэл : current

Ядуурлын түвшин аймгаар



Ядуурлын түвшин аймгаар : test  
Ядуурлын түвшин аймгаар : current

## ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Баян-Өлгийн аймгийн ДНБ-н 2020 онд 469.7 тэрбум төгрөгт хүрсэн ба 2010 оноос 4.3 дахин нэмэгдсэн байна. ДНБ-н өсөлтийн хувь 2010- 2015 онуудад эрчимтэй өссөн бол 2015-2017 онуудад тогтворжин 2018 оноос хойш өсөлт үзүүлсэн байна.



График 73: Баян-Өлгий аймгийн ДНБ

4.3 дахин өссөн нь баруун 5 аймгаас хамгийн бага өсөлт үзүүлсэн байна. Баруун бүсийн аймгаас Говь-Алтай аймгийн ДНБ 6.2 дахин нэмэгдсэн бол Увс аймаг хамгийн ойрхон буюу 4.4 дахин нэмэгдсэн байна.



График 74: Баруун бүсийн аймгийн ДНБ-н өсөлт




График 75: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн бүтцийн хэтийн төлөв



## Цаашдын чиг хандлага

Баян-Өлгий аймгийн ДНБ-ийг тооцоолоход эдийн засгийн 7-н салбарыг салган загварчилсан бөгөөд загварын үр дүнд ДНБ-н цаашид тогтмол нэмэгдэн 2030 онд 1.5 их наяд төгрөгт хүрэх боломжтой болохыг харуулсан.




График 76: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн хэтийн төлөв

Мөн энэхүү загвараас сум тус бүрийн ДНБ-г салган харах боломжтой бөгөөд 2030 онд Ногооннуур сумын ДНБ хамгийн өндөр өсөлт үзүүлэх боломжтой болохыг харуулсан байна. Үүний дараа Цэнгэл сумын ДНБ бусад сумдаас илүү нэмэгдэх төлөвтэй байна.




График 77: Баян-Өлгий аймгийн эдийн засгийн хэтийн төлөв сумдаар




График 78: Ногооннуур сумын эдийн засгийн хэтийн төлөв сумдаар

## Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн

Баян-Өлгий аймгийн нэг хүнд оногдох ДНБ 2010 онд 1.2 сая төгрөг байсан бол 2020 онд 4.4 сая хүртэл нэмэгдсэн байна. Хэдий өссөн боловч нэг хүнд оногдох ДНБ-н нь Баруун бүсийн дунджаас 26% улсын дунджаас 61% бага байна.




График 79: Баян-Өлгий аймгийн нэг хүнд оногдох ДНБ



График 80: Улсын болон Баруун бүсийн нэг хүнд оногдох ДНБ

Баян-Өлгий аймгийн нэг хүнд оногдох ДНБ-н өсөлт харьцангуй бага байгаа бөгөөд 2030 онд 11.25 сая төгрөгт хүрэх төлөвтэй байна. Иймд Баян-Өлгий аймгийг үсрэнгүй хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.




График 81: Баян-Өлгий аймгийн нэг хүнд оногдох ДНБ

Нэг хүнд оногдох ДНБ-ыг 2030 онд сумдаар ангилан харвал Алтанцөгц болон Толбо сумд хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.




График 82: Баян-Өлгий аймгийн нэг хүнд ногдох ДНБ сумаар

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Баян-Өлгий аймгийн ажил эрхлэлт 2010- 2015 онуудад тогтвортой байсан бол 2015 оноос 2018 он хүртэл эрчимтэй нэмэгдэн 48 мянгад хүрсэн бол 2019 оноос 25 мянга хүртэл буурсан байна. Энд бид статистик бүртгэлийн алдаа гарсан гэж үзэж байна.

Жич:1212.mn болон Баян-Өлгий аймгийн статистикийн эмхэтгэл тоо зөрүүтэй байсан.



График 83: Ажил эрхлэлтийн түүхэн тоо

Баян-Өлгий аймгийн ажиллах хүч 2020 онд 17.5 мянга хүртэл буурсан бөгөөд цаашид өсч 2030 он гэхэд 25 мянга хүрэх боломжтой байна. Энэ нь Баян-Өлгий аймгийн 15-с дээш насны хүн амаас ажиллах хүчнээс гадуурх хүн амыг хассан дүн юм.





График 84: Ажиллах хүч сумаар


Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо 2020 оноос тогтмол байх төлөвтэй байна.






**График 87: Аймгийн нийт ажилгүйдлийн түвшин**

Ажилгүйдлийн түвшинг сумдаар ангилан харвал 2030 онд Өлгий сумын ажилгүйдлийг түвшин хамгийн өндөр байгаа бол 2030 онд Дэлүүн сумын ажилгүйдлийн түвшин 17.04 болж буурах төлөвтэй байна. 2020 онд Дэлүүн сумын ажилгүйдлийн түвшин 21.65 тай байна. Бусад сумдын түвшин ойролцоо байгаа бөгөөд ажилгүйдлийн түвшин дунджаар 6.11 байна.




**График 88: Ажилгүйдлийн түвшин сумаар**

Ажилгүйдлийн түвшин буурснаар аймгийн хэмжээнд ажилгүй хүний тоо дунджаар 7.5 мянга хүрнэ. Ингэснээр Баян-Өлгий аймгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 60% хүрэх боломжтой байна.



**График 89: Нийт ажилгүй иргэд**

Ажилгүй иргэдийн тоог сумдаар салган харвал 2030 онд Өлгий суманд хамгийн өндөр буюу 6 мянган ажилгүйчүүд байгаа бол Дэлүүн сум 2030 онд 475 ажилгүй иргэнтэй байх төлөвтэй байна.



**График 90: Ажилгүй иргэд сумаар**

## СИМУЛЯЦИ

Баян-Өлгий аймгийн загварыг 2010-2020 оны суурь статистик мэдээллийг үндэслэн 2030 он хүртэл загварчилан ердийн өсөлтийг тодорхойлсон. Үүний үр дүнд Баян-Өлгий аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан төлөвлөгөө, арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр Баян-Өлгий аймгийн хүн ам, эдийн засаг буюу ДНБ, нэг хүнд оногдох ДНБ, ажил эрхлэлт, ажилгүйдэл, ажилгүйдлийн түвшин зэрэг нийгэм, эдийн засаг, байгаль орчны үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөхийг харах зорилготой. Ингэснээр Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх хөгжлийн цогц төлөвлөгөөг гарган ажиллах боломж бүрдэх юм.

### СИМУЛЯЦИ 1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУУТ

Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын хөгжүүлэхийн тулд байгалийн үзэсгэлэнт газрууд, угсаатны өвөрмөц онцлогыг түшиглэн хөгжүүлэхээр аялал жуулчлалын “Урд чиглэлийн маршрут”, “Баруун хойд чиглэлийн маршрут”, “Хойд чиглэлийн маршрут”, “Зүүн өмнөд чиглэлийн маршрут”-ыг гарган хөгжүүлэх төлөвлөгөө гаргасан байна. Энэхүү аялал жуулчлалын маршрутыг хэрэгжүүлсэнээр аялал жуулчлалын хөгжилд том эффект гарахгүй бөгөөд үр дүнд нь 2000 орчим жуулчид нэмэгдэх боломжтой байна.




График 91: Нийт жуулчид, симуляц

Энэхүү маршрутын нөлөөг нэмэгдүүлэхийн тулд чиглэлийн дагуух сумдыг 2023 онд аймгийн төвтэй **хатуу хучилттай авто замаар** холбоход 2030 онд Баян-Өлгий аймагт ирэх жуулчдын тоо 48.8 мянгад хүрэн 5000 орчим жуулчдаар нэмэгдэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл зүгээр маршрут гаргаад жуулчин татахгүй бөгөөд дэд бүтцийг илүү сайжруулах хэрэгтэй гэдэг санаа харагдаж байна.




График 92: Нийт жуулчин симуляц

Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 500 орчим аялал жуулчлал дагасан ажлын байр нэмэгдэх боломжтой байна.




График 93: Нийт аялал жуулчлал дагасан ажил эрхлэлт, симуляц

Аялал жуулчлал дагасан ажил эрхлэлтийн өсөлтийг сумдаар салган харвал Өлгий сумаас гадна Улаанхус, Цэнгэл зэрэг сумдад өндөр нөлөө үзүүлэх боломжтой байна.

Мөн Баян-Өлгий аймгийн аялал жуулчлалын орлого 2 тэрбум төгрөгөөр нэмэгдэх боломжтой.




График 94: Аймгийн аялал жуулчлал сумаар

Дээрх сум хоорондын хатуу хучилттай автозамын нөлөөгөөр аялал жуулчлалаас гадна бусад төрлийн үйлчилгээний ажил эрхлэлт нэмэгдэх бөгөөд аймгийн хэмжээнд 1900 ажлын байрыг шинээр нэмэгдүүлэх боломжтой байна.



Баян-Өлгий аймгийн үйлчилгээний салбарын нийт ажил эрхлэлт




График 95: Үйлчилгээний салбарын нийт ажил эрхлэлт, симуляц

Үүний үр дүнд Баян-Өлгий аймгийн ажилгүйдлийн түвшин 2030 онд 15.01- ээс 13.73 хүртэл буурах боломжтой байна.

Нийт ажилгүйдлийн түвшин




График 96: Нийт ажилгүйдлийн түвшин, симуляц

Аялал жуулчлалын 4-н маршрут болон хатуу хучилттай автозамын эффектийг ажилгүйдлийн түвшинд хэрхэн яаж нөлөөлж байгааг сум тус бүрээр салган харвал 2030 онд Баяннуур, Бугат, Буянт, Дэлүүн, Улаанхус зэрэг сумдад өндөр нөлөө үзүүлж байна.




График 97: Ажилгүйдлийн түвшин сумаар

## СИМУЛЯЦИ 2: НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ

Баян-Өлгий аймгийн нисэх онгоцны буудал нь 1958 онд суурь нь тавигдсан бөгөөд цагт 50 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай баригдсан тус нисэх буудал өдгөө 75-100 хүний багтаамжтай агаарын хөлгүүдийг хүлээн авч байна. Гадаад дотоодын зорчигчийн тоо нэмэгдэж, зорчигчийн тоо жилд дунджаар 40 орчим мянгад хүрч, хүчин чадал хүрэлцэхгүй байгаа тул Өлгий нисэх буудлыг өргөтгөх шаардлагатай байна.

Иймээс Баян-Өлгий аймгийн нисэх онгоцны буудлын өргөтгөн цагт 200 хүн хүлээн хүчин чадалтай олон улсын зэрэглэлтэй, шөнө нислэг хүлээн авах боломжтой онгоцны буудал 2023 онд барьснаар Баян-Өлгий аймгийн эдийн засгийн салбаруудад шинээр 3000 ажлын байр бий болох бүрэн боломжтой байна.




График 98: Нийт амжил эрхлэлт, симуляц 2

Шинээр нэмэгдэх 3000 ажлын байрны нөлөөгөөр 2030 онд Баян-Өлгий аймгийн ажилгүйдлийн түвшин 15.01% хүрэх төлөвтэй байсан бол 12.98% хүртэл буурах эерэг нөлөө үзүүлж байна.




График 99: Нийт ажилгүйдлийн түвшин, симуляц 2

Энэхүү нисэх онгоцны буудал нь Баян-Өлгий аймгийн аялал жуулчлал, үйлчилгээний салбарт томоохон нөлөө үзүүлэх бөгөөд гадаад, дотоодын жуулчдын тоо 2030 онд 43.5 мянгаас 52.5 мянгад хүрч өндөр өсөлт үзүүлэх төлөвтэй байна. Аялагчдын тоог даган аялал жуулчалын салбарын ажил эрхлэлт 17% нэмэгдэн аялал жуулчлалын орлого 20 тэрбум төгрөгт хүрэх боломжтой байна.

## Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн салбар

### СИМУЛЯЦИ 3: АРС ШИР

Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2021 онд 900 мянга гаруй арьс, шир бэлтгэсэн бөгөөд энэ тоо 2030 он гэхэд 1400 мянгад хүрэх төлөвтэй байна.




График 100: Нийт арьс шир, симуляц 3


Үүнээс үнэгүйдэн хаягдаж байгаа арьс, ширний хэмжээ 2021 онд 450 мянга байгаа бол 2030 онд 800 мянга хүртэл нэмэгдэх төлөвтэй байна.



График 101: Үнэгүйдсэн арьс ширний хэмжээ


Иймээс хаягдал арьс ширний хэмжээг багасгахын тулд арьс шир болосвруулах анхан шатны үйлдвэр барих шаардлагатай байна.

Энэхүү үйлдвэрийг 2025 онд барьж ашиглалтанд оруулсанаар үнэгүйдсэн арьс ширний хэмжээ 2030 онд 450 мянга хүртэл буурах боломжтой байгаа бөгөөд боловсруулсан арьс ширний хэмжээ 700 мянгад хүрч нэмэгдэх боломж байна.




**График 102: Нийт боловсруулсан арьс, симуляц 3**

Үүний үр дүнд аймгийн хэмжээнд 950-1100 ажлын байр бий болох боломжтой байна.



**График 103: Арьс ширний үйлдвэрлэлийн ажил эрхлэлт**

Дээрх ажлын байруудыг сумдаар задлан харвал



**График 104: Хагас болон бүтэн боловсруулах үйлдвэрийн ажилчид сумаар**

#### СИМУЛЯЦИ 4: НОЛУУР

Аймгийн хэмжээд 2030 он гэхэд 500-550 тонн түүхий ноолуур бэлтгэх боломжтой байна.



График 105: Нийт ноолуурын хэмжээ, симуляц 4

Үүний үр дүнд 2030 онд зөвхөн ноолуураас аймгийн хэмжээнд 56.13 тэрбум төгрөгийн орлого олно.



График 106: Ноолуурын нийт орлого аймгаар, симуляц 4

Харин 2025 онд аймгийн хэмжээнд ноолуур угаах, самнах үйлдвэрлэлийг бий болгоход 2030 онд 17.6 тонн ноолуурт анхан шатны боловсруулалт хийх боломжтой болно.

Ингэснээр ноолуураас олох орлого 100.8 тэрбум төгрөг хүртэл нэмэгдэх боломжтой байна.




График 107: Ноолуурын нийт орлого аймгаар, симуляц 4

## СИМУЛЯЦИ 5: НООС

Баян-Өлгий аймгийн хэмжээд 2030 онд 959 тонн ноос бэлтгэгдэх боломжтой байна. Ингэснээр ноосноос олох орлого өнөөгийн үнэ цэнээр 4.1 тэрбум төгрөгт хүрнэ.




График 108: Нийт ноосны хэмжээ, симуляц 5




График 109: Ноосноос олох орлого, симуляц 5

Энд бид ноолууртай адилаар хонь болон тэмээний ноосны угаах, самнах анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрүүдийг барьж туршилт, симуляци хийн үр дүнг харж болно.

## СИМУЛЯЦИ 6: САРЛАГИЙН ХӨӨВӨР




График 110: Нийт сарлагийн тоо, симуляц 6

2030 онд Баян-Өлгий аймгийн сарлагийн тоо 124 мянгад хүрэх төлөвтэй байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 2021 онд 33.8 тонн сарлагийн хөөвөр бэлтгэсэн бол 2030 онд 59.5 тонн хүрэх төлөвтэй байна.




**График 111: Нийт сарлагийн хөөврийн хэмжээ, симуляц 6**

Энд бид ноолууртай адилаар хөөврийг угаах, самнах, ээрэх, нэхэх сүлжих үйлдвэрүүдийг барьж туршилт, симуляци хийж болно.


### Аймгийн төсвийн орлого

Аймгийн төсвийн нийт орлого 2019 онд 12439.1 сая төгрөг болж, өнгөрсөн оны татварын орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад 12.1 хувиар буюу 1368.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн орлогын 16.6 хувийг төвлөрсөн төсвийн орлогын албан татвар, 57.5 хувийг хүн амын орлогын татвар, 9.4 хувийг байгалийн нөөц ашигласны төлбөр, үлдсэнийг бусад татварын орлого эзэлж байна.




**График 113: Аймгийн төсвийн орлого ба улсын төсвийн орлого**

Малын гаралтай түүхий эдийг 2024 оноос боловсруулж чадвал Улсын төсвөөс авах татаасын хэмжээ 30 гаруй тэрбум төгрөгөөр буурах боломжтой байна.




### Байгаль орчин

Баян-Өлгий аймагт хэрэгжүүлэх Эдийн засгийн хөтөлбөрүүд нь байгаль орчинд ээлтэй юу? хор нөлөөтэй юу? гэдгийг тооцоолж гаргахын тулд эдгээр секторуудыг бүтээлээ. Байгаль орчны хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдол/Өлгий сум/, хог хаягдал, усны хэрэглээ гэсэн үзүүлэлтүүдийг энд авч үзлээ.



**График 114: Аймагын байгаль орчны гол үзүүлэлтүүд**

Өлгий сумын гэрт болон галлагаатай сууцанд амьдардаг айл өрхийн 10 хувийг төвийн дулаан хангамжтай орон сууцанд оруулах хөтөлбөрийг хэрэгжүүлбэл Өлгий хотын агаарын бохирдол 12 хувиар буурна.



### Хүний хөгжлийн индекс

Хүний хөгжлийн индекс нь хүний чадавхийн хөгжлийг харуулах бөгөөд эрүүл саруул байж, урт удаан наслах; эрдэм мэдлэг эзэмших; амьжиргааны зохистой нөхцөлд аж төрөх гэсэн хүний амьдралын үндсэн гурван хэмжигдэхүүнийг илэрхийлнэ.



Баян-Өлгий аймгийн Хүний хөгжлийн индексийг нийт сумдаар тооцоолоход 2030 онд дундажаар 0.75-д хүрч байгаа бөгөөд Өлгий сумын индекс 0.85-д хүрэх боломжтой байна. Энэ нь "Алсын хараа 2050"-д тусгагдсан зорилтот түвшин болох 0.85 гэсэн хүний хөгжлийн индекстэй нийцэж байна.



**График 115: Аймгийн хүний хөгжлийн индекс**

## ДУГНЭЛТ

Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлох зорилготой Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс боловсруулан гаргадаг "Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан"-гийн судалгаагаар 2021 оны байдлаар Баян-Өлгий аймаг 13-р байрт орсон үзүүлэлттэй байна. Хүн амын дундаж наслалтаар Баян-Өлгий аймаг улсад 3-р байранд буюу дундаж наслалтаар тэргүүлж байна. Гэсэн хэдий ч, 2021 оны байдлаар Баян-Өлгий аймгийн ажилгүйдлийн түвшин 20.9% байна буюу баруун бүсийн дундажаас 3.7 хувиар, улсын дундажаас 4.8%-иар илүү байгаа бөгөөд ажилгүйдэл хамгийн их 3 аймгийн нэг болж байна. Хэдийгээр баруун бүсээс хамгийн олон хүн амтай аймаг боловч эдийн засгийн үзүүлэлт, нэг хүнд ДНБ-ий хэмжээ хамгийн доогуур байна.

Монгол улсын урт хугацааны бодлого Алсын хараа 2050-д Баян-Өлгий аймгийг аялал жуулчлалын чиглэлээр хөгжүүлэх гол бүс нутгаар төлөвлөжээ. (Өрнөд Монголын Эдийн Засгийн Хөгжлийн Тэнхлэг, Алтайн Соёл, Байгалийн Нөөц, Ногоон Хөгжлийн Бүс). Энэхүү арга хэмжээнүүд нь тус нутгийн эдийн засагт эерэг нөлөө авчрах нь симуляцийн үр дүнгээс харагдаж байна.

Түүнчлэн, тус аймгийг худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхай, хөдөө аж ахуй болон хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах чиглэлээр хөгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд ингэснээр эдийн засгийн бүтцийг тэнцвэржүүлж, олон талтайгаар хөгжүүлэхэд сайнаар нөлөөлөх юм.

Баян-Өлгий аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчныг хамгаалах чиглэлээр бидний хийсэн 2022-2030 оны төсөөлөл нь өмнөх он жилүүдийн бодит гүйцэтгэл болон МУТХҮБ-2030 болон Алсын хараа 2050-д дэвшүүлсэн зорилтот түвшинд тулгуурласан болно. Ирэх он жилүүдийн нөхцөл байдал тодорхойгүй, олон хүчин зүйлийг урьдчилан таамаглахад хүндрэлтэй байна. Тухайлбал коронавирусын нөлөө, хил гаалийн хориг саад нь таамаглал гаргахад бэрхшээл учруулж байна. Бидний дээрх төсөөллүүд бодит амьдралд хэрэгжих эсэх нь олон хүчин зүйлээс хамаарна.

Төрийн бодлого тогтвортой байж, аймгийн засаг дарга, тамгын газрын дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг бодитой хэрэгжүүлсэн нөхцөлд дунд хугацааны хөгжлийн таамагласан түвшинд хүрч, дэвшүүлсэн зорилт хэрэгжих үндэслэлтэй гэж үзэж байна. Нөгөө талаар, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн өнөөгийн тогтолцоогоо хөгжүүлж, бидний хийсэн таамаглал төсөөллийг салбарын мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор аймгийн хэмжээний иж бүрэн төлөвлөгөө болгон нарийвчлан тодорхойлж, эрх бүхий байгууллагаас албан ёсоор батлан, түүнийг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай.

1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн хийх үйлдвэрүүдийг аймаг орон нутагт барьж, хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах, хөдөө орон нутгийг хөгжүүлэх.

2. Боловсруулах салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх нөхцөлийг бүрдүүлэх, үнэт цаасны зах дээрээс компаниуд хувьцаа, бонд гарган санхүүжилт олох.

3. Хариуцлагатай уул уурхайг дэмжиж эрдэс баялгийг баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг барих /Асгатын мөнгөний орд/.

4. Баян-Өлгий аймаг дахь байгалийн үзэсгэлэнт газрууд ялангуяа Алтай таван богд байгалийн цогцолборт газар, ховор ан агнуур, мөн Казах үндэстний ёс заншил соёл дагасан аялал жуулчлалыг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах.

5. Аймгуудын эдийн засгийн бусад салбаруудыг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эдийн засгийг төрөлжүүлэх эсвэл зөөлөн болон хатуу дэд бүтцийг сайжруулах замаар аймгийн тогтвортой хөгжлийг дэмжих хэрэгтэй байна.

6. Цагааннуур болон Даянгийн хилийн боомтыг аймгийн төв Өлгий хоттой хатуу хучилттай автозамаар холбох, олон улсын зэрэглэлтэй болгох, эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах хэрэгтэй байна.

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд Баян-Өлгий аймгийн нийгэм, эдийн засгийн өсөлт нэмэгдэж, засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хөгжлийн зорилтот хөтөлбөр, тогтвортой хөгжлийн зорилт, алсын хараа 2050 зэрэг бодлогын баримт бичгүүдэд авч үзсэн аймгийн зорилтот түвшин биелэх боломжтой болно.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Дотоод эх сурвалжууд

1. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016.
2. Алсын хараа-2050, 2020.
3. Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл. 2020
4. ҮСХ, "Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо", 2017.
5. ҮСХ, "Монгол Улсын Статистикийн эмхэтгэл", 2017.
6. ҮСХ, "Монгол Улсын Статистикийн эмхэтгэл", 2018.
7. ҮСХ-ны цахим хуудас, [www.1212.mn](http://www.1212.mn).
8. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2014-2021 он.
9. Баян-Өлгий аймгийн статистикийн эмхэтгэл 2010-2021 он
10. Баян-Өлгий аймгийн ажил эрхлэлтийн байдал 2013-2018 он
11. Баян-Өлгий аймгийн хүн амын орон сууцны 2020 оны ээлжит тооллого
12. Баян-Өлгий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал 2021 он
13. Баян-Өлгий аймгийн товч таницуулга 2021 он
14. Баян-Өлгий аймгийн хүн ам, өрхийн төлөв байдал 2019
15. "Монгол Улсын хөдөлмөр эрхлэлт" симтемийн динамик загвар 2021 он
16. "Эдийн засагт хэрэгжих томоохон төслүүдийн эрэмбэ" системийн динамик загвар 2021 он
17. "Монгол Улсын бүсчилсэн хөгжил" системийн динамик загвар 2020 он
18. Д.Бадарч, Б.Очирбат, Б.Энх-амгалан. "Системийн динамик загварчлалын үндэс" УБ 2003 он.
19. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. [www.1212.mn](http://www.1212.mn)
20. Баян-Өлгий аймгийн статистик мэдээллийн сан.
21. Б.Очирбат "Бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн бодлогыг системийн динамик загварчлалын аргаар боловсруулах нь" 2002 он.
22. "Т-21 Дундговь" системийн динамик загвар 2019 он.
23. Монгол улсын ноолуурын салбарын динамик загвар 2019 он.
24. Б.Энх-Амгалан, Ц.Сэлэнгэ, Ц.Базарханд, Д.Зэлмэ "Шилжилт хөдөлгөөний загвар боловсруулах" судалгааны тайлан 2021 он.

### Гадаад эх сурвалжууд

25. [John D. Sterman](#), 2000, Systems Thinking and Modeling for a Complex World
26. Mongolia livestock sector study, 2009, World bank
27. "World-3" системийн динамик загвар, 2014 он
28. "Threshold21 Uruguay", Урагвай улсын системийн динамик загвар, 2014 он
29. Jay W.Forrester "Urban dynamics" 1968. MIT press
30. D.H.Meadows. "The Limits to Growth" 1972. New-York
31. Ф.С.Шортер, Р.Сендек, В.Баюми, Хүн амын ирээдүйн төлвийг тооцоолох аргууд. Нью-Йорк, 1995
32. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд. Дэлхийн банк, 1997, Вашингтон

### Хэлэлцүүлэг болон сургалтын үр дүн

#### Томилот 1.

**Зорилго:** Баян-өлгий аймагт хийгдэж буй системийн динамик загварчлал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг аймгийн удирдлагуудад танилцуулах, үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглах боломжийг ойлгуулах, ажлын явцын танилцуулга хийх, аймгийн өмнө тулгамдсан асуудлууд, хэрэгцээ шаардлагыг өөрсдөөр нь тодорхойлуулах, зарим судалгааны материалыг олж авах.

Баян-Өлгий аймагт 02.24-03.02 хооронд Б.Ууганбаяр, Ж.Жаргал нар ажилласан.

Хэлэлцүүлгийн хөтөлбөр

1. Системийн динамик загварчлалын танилцуулга /Б.Ууганбаяр/
2. Баян-Өлгий аймгийн хөгжлийн стратеги, төлөвлөлт /Ж.Жаргал/  
Оролцогчид : Засаг даргын орлогч С.Хонаев, Тамгын газрын дарга Б.Мухамед, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын газрын дарга Х.Анар, мэргэжилтэн Т.Ариунцэцэг, Статистикийн хэлтэсийн дарга Ерлан, мэргэжилтэн Зоя, Дина, Бахыт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга А.Галия, Б.Айнур, Бейсэнгүл, Улсын бүртгэлийн газрын хэлтэсийн дарга Аманбек, Байгаль, орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Б.Гүлжан нар оролцсон.

Хэлэлцүүлэгт оролцсон орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдээр Баян-Өлгий аймгийн өмнө тулгамдсан асуудлууд, хэрэгцээ шаардлагыг эрэмбэлүүлсэн.

№	Асуудал, хэрэгцээ	Шалтгаан	Хамрах хүрээ	Асуудлын эрэмбэ
1.	Ажилгүйдэл	1. Иргэдийн ажил хийх сонирхол бага 2. Ажлын байр олддоггүй. 3. Цалин бага	Хөдөлмөрийн насны иргэд	<b>4</b>
2.	Үйлдвэржилт, ЖДҮ	1. Зээлийн хүү 2. Төрийн албаны хүнд суртал	Бизнес эрхлэгчид, Төрийн алба	<b>5</b>
3.	Хүнсний аюулгүй байдал,	1. Хяналт, шалгалт сул 2. Чанарын баталгаагүй, хямд үнэтэй бүтээгдэхүүн 3. Иргэдийн хандлага, мэдлэг	Мэргэжлийн хяналтын байгууллага, худалдаа үйлчилгээ эрхлэгчид, иргэд	<b>7</b>
4.	Эрүүл мэндийн үйлчилгээ	1. Эмнэлэгийн орчин, тоног төхөөрөмжийн шинэчлэл хангалтгүй 2. Эмч нарын мэдлэг чадвар 3. Шинэ менежмент нэвтрүүлэх 4. Хүн амын тоо өсч байгаа	Эрүүл мэндийн байгууллага, ажилтан албан хаагчид, иргэд	<b>1</b>
5.	Боловсролын чанар	1. Багш нарын ур чадвар, монгол хэлний мэдлэг сайжруулах 2. Эцэг эх, сургууль, олон нийтийн хамтын ажиллагаа сул	Сургалтын байгууллагууд, багш, эцэг эх, иргэд	<b>2</b>
6.	Алслагдсан байдал, зам тээвэр	1. Нийслэл Улаанбаатар хотоос хамгийн алслагдсан аймаг 2. Тээврийн зардал өндөр	Аймаг бүхэлдээ	<b>10</b>
7.	Авлига, төрийн албаны хүнд суртал	1. Төрийн албан хаагчийн ёс зүй 2. Чадвартай, сайн боловсон хүчин дутмаг 3. Ил тод, нээлттэй байдлыг сайжруулах 4. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг сайжруулах	Төрийн алба, иргэд	<b>3</b>
8.	Байгаль орчны асуудлууд: 1. Бэлчээрийн даац, 2. Агаарын бохирдол 3. Хог хаягдал 4. Ундны ус	1. Бэлчээрийн менежмент муу 2. Түүхий нүүрс, мод түлэх 3. Иргэдийн хандлага, соёл 4. Уур амьсгалын өөрчлөлт 5. Хог хаягдлын менежмент хариуцсан байгууллага, эзэнгүй	Хариуцсан төрийн байгууллага, иргэд	<b>6</b>
9.	Хөдөө аж ахуйн хөгжил	1. Газар тариалангийн хөгжил муу 2. Төрөөс дэмжлэг сул 3. Нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангах	Аймаг бүхэлдээ	<b>8</b>
10.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх	1. Бодлого, эрх зүйн орчин шинэчлэх шаардлагатай	Хувийн хэвшил, иргэн, төр	<b>9</b>

		2. Алслагдсан байдал 3. Шинэ бренд, үйлчилгээг санал болгох		
--	--	--	--	--

## Томилолт 2.

Баян-Өлгий аймагт 03.19-03.26 хооронд Б.Ууганбаяр, Д.Ариун-эрдэнэ нар ажилласан.

**Зорилго:** Баян-Өлгий аймагт хэрэгжих Асгатын мөнгөний ордыг ашиглах, Аялал жуулчлалыг хөгжүүлэх, Цагааннуур болон Даянгийн боомтыг олон улсын чанартай болгох зэрэг томоохон төслүүдийн нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөг тооцоолж, гарсан үр дүн Ерөнхий сайдад танилцуулж тодорхой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх, Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газруудад ажиллаж шилжилт хөдөлгөөн болон хөдөлмөр эрхлэлтийн нарийвчласан тоон мэдээлэл цуглуулах.



## Томилолт 3.

Баян-Өлгий аймагт 05.17-05.24 хооронд Б.Ууганбаяр, Д.Ариун-эрдэнэ, У.Баясгалан, М.Гэрэлт-од нар ажилласан.

**Зорилго:** Системийн динамик загварыг хүлээлгэн өгөх, иргэдийн хурал, агентлагуудын дарга нарт танилцуулах, сургалт явуулах

